

From
the People of Japan



Зөвлөх үйлчилгээний тайлан

Төслийн нэр: МОН 9202: Улаанбаатар хотын хүнсний хаягдлыг дахин боловсруулах

Захиалагч: Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын Алба

Хамтран ажиллах зөвлөх үйлчилгээ: CS1- Хүнсний хаягдлыг дахин боловсруулах
(Британий Стандартчилалын Байгууллага, Төв Азийн Хөрс Судлалын Холбооны түншлэл)

Хүнсний хог хаягдлыг цуглуулах, боловсруулах хууль, эрх зүйн болон байгууллагын тогтолцооны тайлан 1-р хэсэг

(Үйл ажиллагаа 3.7. Туршилтын төслүүдийн цар хүрээг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн болон байгууллагын тогтолцооны судалгаа)

2023 оны 5-р сарын 31

2023 оны 7-р сарын 19, 8-р сарын 30-нд нэмж засварлав

Санамж:

Энэхүү зөвлөхийн тайлан нь АХБ болон Засгийн газрын байр суурийг илэрхийлэхгүй ба уг тайлангийн агуулгад АХБ, Засгийн газар хариуцлага хүлээхгүй

Агуулга

1	Тайлангийн хураангуй	3
2	Танилцуулга	6
2.1	Оршил.....	6
2.2	Хамрах хүрээ, арга зүй	6
2.3	Тайлангийн зохион байгуулалт	7
3	Байгаль орчны эрх зүйн орчин	8
3.1	Хог хаягдлын тухай хууль	8
3.2	Байгаль орчны холбогдох хууль тогтоомж.....	9
3.3	Журам.....	11
3.4	Стандартууд.....	11
4	Байгууллагын бүтэц, тогтолцоо	12
4.1	Засгийн газрын бүтэц	12
4.2	Байгууллагын эрх, үүрэг	12
5	Үндэсний хөгжлийн бодлого	16
5.1	Монгол Улсын хөгжлийн бодлого.....	16
5.2	Монгол Улсын эдийн засгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл.....	19
5.3	Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр.....	19
6	Улаанбаатар хотын хөгжлийн бодлого	21
7	Хог хаягдлын менежменттэй холбоотой хууль эрх зүй, тавигдах шаардлага	22
7.1	Хог хаягдал булшлах (ландфил).....	22
7.2	Хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах	23
7.3	Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх	24
8	Хог хаягдлын менежментийн дэд бүтэц	27
8.1	Хог хаягдлыг хадгалах, ангилах	27
8.2	Хог хаягдлыг цуглуулах, ачих.....	27
8.3	Хог хаягдлын тээвэрлэлт	28
8.4	Хүнсний хог хаягдлыг бордоогоор дахин боловсруулах	29
8.5	Хог хаягдлыг булшлах, ландфиллын үйл ажиллагаа	29
9	Хог хаягдлын менежментийн санхүүжилт ба төсөв	30
10	Хүнсний хаягдлын менежментийн үе шат	32
10.1	Хүнсний хаягдлыг хадгалах.....	32
10.2	Хүнсний хаягдлыг цуглуулах, тээвэрлэх	32
10.3	Хүнсний хаягдлыг дахин боловсруулалт, компост	33
10.4	Хүнсний хаягдлыг устгах.....	33
10.5	Тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт	33
10.6	Удирдлага ба зохион байгуулалт	33
10.7	Санхүүгийн систем	34
11	Дүгнэлт	35
12	Хавсралт 1	36

Энэхүү тайлангийн тэмдэглэл:


Энэхүү баримт бичигт "хууль тогтоох хэрэгсэл" гэсэн нэр томъёог ашигласан болно. Хууль тогтоох баримт бичиг нь хууль тогтоомжийн эрх мэдлийн хүрээнд гаргасан, хууль тогтоомжийг хэрхэн тайлбарлах, хэрэгжүүлэх талаар тодорхой дэлгэрэнгүй мэдээлэл, практик зааварчилгаа өгөхөд тусалдаг баримт бичиг юм.

Хууль тогтоох хэрэгсэл нь эрх мэдлийн цар хүрээ болон холбогдох хууль тогтоомжоос хамааран журам, дүрэм, тогтоол, тушаал, захирамж зэрэг янз бүрийн хэлбэртэй байж болно. Эдгээр нь хуулийг үр дүнтэй хэрэгжүүлэх болон хэрэгжүүлэхэд шаардлагатай дэлгэрэнгүй заавар, журам, дүрмийг тусгасан байдаг.

1 Тайлангийн хураангуй

Энэхүү тайланд хүнсний хаягдлаас компост боловсруулах хүртэл цогц үе шатыг хамарсан хууль тогтоомжийн үндсэн хэрэгслүүдийг тайлбарласан болно. Энэ нь хүнсний хаягдлыг боловсруулах стратегийн зорилго болон дагаж мөрдөх шаардлагатай зарим тодорхой шаардлагууд, эрх зүйн хэм хэмжээний талаарх ойлголтыг өгөх юм.

Хүнсний хаягдлаас компост боловсруулах хүртэл үе шат



Хууль тогтоомж

Хог хаягдлын менежментийг зохицуулах үндсэн эрх зүйн баримт бичиг нь **Хог хаягдлын тухай хууль** юм. Энэ хуулиар хог хаягдлыг ангилах, хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах (бордоо болгох) болон устгахад тавигдах ерөнхий шаардлагыг хуульчлан тогтоосон болно. Гэсэн хэдий ч хүнсний хаягдлын менежментийг зохицуулсан тусгайлсан хууль, журам одоогоор боловсруулагдаагүй байна.

Хог хаягдлын тухай хуулийг анх 2012 онд баталж, 2017 онд шинэчлэн найруулан бөгөөд уг хууль нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, хог хаягдлыг дахин боловсруулан эдийн засгийн эргэлтэд оруулах замаар байгалийн нөөц баялгийг хамгаалах зорилготой юм. Энэхүү хуулиар энгийн болон аюултай хог хаягдлын менежментийн үйл ажиллагааг зохицуулах бөгөөд үүнд цацраг идэвхт хаягдал хамаарахгүй болно.

Монгол Улсын Үндсэн хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс хог хаягдлын тогтвортой менежментийг илүү өргөн хүрээнд хангасан нэмэлт хуулиуд бий. Эдгээр хуулиудад байгаль орчныг хамгаалах, химийн хорт болон аюултай бодис, ургамал хамгаалал, ус, агаарын чанар, тусгай зөвшөөрөл олгох, хот байгуулалт, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ зэрэг хуулиуд багтсан.

Стратегийн бодлого

Монгол Улсын засаглалын тогтолцоо нь дөрвөн шатлалтай төрийн бүтцээс бүрдэх бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг дөрвөн шатанд хуваарилж, хэрэгжүүлэх эрх зүйн тогтолцоотой.

Хөгжлийн үндсэн бодлого нь “Алсын хараа-2050” бөгөөд үүгээр есөн зорилт бүхий урт хугацааны хөгжлийн стратегийг тодорхойлсон. Үүнд хог хаягдлыг дахин боловсруулах, байгаль очинд сөрөг нөлөөгүй хог хаягдлыг цуглуулах, устгах зорилтууд багтсан болно. “Алсын хараа-2050” хөтөлбөрт тусгагдсан хог хаягдлын зорилтуудыг тусгасан Монгол Улсын таван жилийн хөгжлийн чиглэл (2021-2025) дунд хугацааны стратегийн баримт бичиг юм.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт хог хаягдлын менежментийг сайжруулах талаар тодорхой ажлууд тусгагдсан болно. Үүнд, “Хүнсний хаягдлыг дахин боловсруулах төсөл”-ийн талаар тусгайлан дурдсан байна.

Улаанбаатар хотыг 2021-2025 онуудад хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр гэсэн хоёр хөгжлийн баримт бичиг байдаг. Үндсэн чиглэл нь байгаль орчны бохирдлыг бууруулах, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах зорилготой бол үйл ажиллагааны хөтөлбөр нь хог хаягдлыг ангилах, дахин боловсруулах байгууламж байгуулах, дахин боловсруулах үйл ажиллагааг нэмэгдүүлэхэд иргэд, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх зорилготой юм. Мөн, Нийслэлийн Засаг даргын мөрийн хөтөлбөрт өдөрт 2,000 кг компост үйлдвэрлэх хүчин чадал бүхий хүнсний хаягдал боловсруулах үйлдвэр байгуулах зорилт тусгагдсан.

Хог хаягдлын менежмент

Хог хаягдлын менежментийн хувьд хогийн төвлөрсөн цэгт хог хаягдлыг дарж, булшлах талаар тодорхой шаардлагыг журмын хүрээнд тавьдаг. Хог хаягдлыг дахин боловсруулах үүрэг бүхий хуулийн этгээд нь Байгаль орчны яамны мэдээллийн сан болон нийслэлийн хог хаягдлын менежмент, хяналтын нэгдсэн цахим системд бүртгүүлж үйл ажиллагааг эрхлэх бөгөөд дүүргийн Засаг даргын зарласан сонгон шалгаруулалтад тэнцэж, гэрээ байгуулсан аж ахуйн нэгжээр дамжуулан хог хаягдал цуглуулах, тээвэрлэх ажлыг гүйцэтгэх боломжтой.

Хог хаягдлын тухай хуульд хог хаягдлыг ангилан ялгах, ангиллын төрлөөр цуглуулах, тээвэрлэх замаар хог хаягдлыг бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэхийг үүрэг болгож, нийтийн эзэмшлийн талбайг цэвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгахад тавигдах шаардлага, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эрх, үүргийг тусгайлан зааж өгсөн. Орон сууцны болон гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгжүүд хог хаягдлаа дахин боловсруулах, дахин боловсруулах боломжгүй, хүнсний хаягдал гэж ангилан ялгах үүрэгтэй.

Мөн Хог хаягдлын тухай хуульд хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлагыг тогтоосон бол Байгаль орчныг хамгаалах тухай хуульд байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх үүрэгтэй болохыг зааж өгсөн байна.

Хог хаягдлын менежментийн санхүүжилт

Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, төвлөрсөн цэгт дарж, булшлах үйл ажиллагааг айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудаас цахилгаан түгээх сүлжээ болон орон суун ашиглалтын байгууллагуудын төлбөрийн системээр дамжуулан цуглуулсан хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого болон нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлдэг. Одоогийн байдлаар орон сууцны айл өрх сард 2,000 төгрөг төлж байгаа бол гэр

хорооллын айл өрх 2,500 төгрөг төлж байна. Хэдийгээр 2017 онд батлагдсан Хог хаягдлын тухай хуулиар хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэг иргэнээр тогтоох, үйлчилгээний хураамж нь хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булшлах үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэхээр заасан боловч өнөөг хүртэл 2006 онд тогтоосон хог хаягдлын үйлчилгээний хураамжид СХД, БЗД, Налайх, Багахангай дүүргээс бусад дүүргүүд өөрчлөлт хийгдээгүй байна.

Хүнсний хаягдлын менежмент

Хүнсний хаягдлын менежментийг зохицуулсан тодорхой журам, дүрэм одоогоор батлагдаагүй байгаа ба хүнсний хаягдлыг тусад нь тээвэрлэх талаар төлөвлөлт, арга аргачлал, дэд бүтэц хараахан бүрдээгүй байна.

Сорилт, бэрхшээл

Улсын хэмжээнд болон Улаанбаатар хотын түвшинд хог хаягдлын менежментийг зохицуулах хууль эрх зүйн иж бүрэн тогтолцоо бий болсон ч хэрэгжилт нь хангалтгүй байна. Энэ нь харилцан хамааралтай хэд хэдэн хүчин зүйлүүдээс шалтгаалж байна. Үүнд:

- Иргэд хог хаягдлыг ангилан ялгаж, хогийн савыг ашиглах талаар ойлголт, мэдлэг дутмаг .
- Хог хаягдлыг цуглуулсны дараа ангилан ялгаж тээвэрлэдэггүй.
- Хог хаягдлыг хогийн бункерээс гараар цуглуулж, ачдаг
- Хог хаягдал тээвэрлэгч машинууд хуучирсан, эвдрэл, гэмтэл их гардаг.
- 2006 онд батлагдсан тарифаар хог хаягдлын үйлчилгээний хураамжийг айл өрхөөс авч байгаа нь үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлж байна.
- 2017 онд УИХ-аар батлагдсан Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хог хаягдлын үйлчилгээний хураамжийг үүсгэж байгаа хог хаягдлын хэмжээнээс хамааруулан тогтооно гэж заасан боловч хэрэгжээгүй
- Хүнсний хог хаягдлыг хэрхэн хадгалах, цуглуулах, тээвэрлэх талаар тусгайлсан журам, дүрэм, зааварчилгаа байхгүй

Хүнсний хаягдлаар компост хийх туршилтын төслийг өргөжүүлэх, тогтвортой байдлыг хадгалах, ялангуяа том хэмжээний туршилтын төслийг дээрх бүх хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай.

2 Танилцуулга

2.1 Оршил

Монгол Улсаас жил бүр 3.4 гаруй сая тонн хатуу хог хаягдал хаягддагийн 42% нь нийслэл Улаанбаатар хотод ногдож байна. Одоогоор эдгээр хог хаягдлын 73% нь хогийн цэгт хаягдаж байгаа ч цөөн аж ахуйн нэгж, иргэд цаас, хуванцар, төмөр, барилгын хог хаягдлыг дахин боловсруулах зорилгоор цуглуулж байна. Хог хаягдлын бүтцийн 30% орчмыг (үнсийг тооцохгүйгээр) хүнсний хаягдал эзэлдэг бөгөөд гол төлөв хогийн цэгт дарж, булшилж эсвэл хууль бусаар ил задгай хаядаг. Хүнсний хаягдлыг ийнхүү хөрсөнд булшилж, ид задгай хаяснаар задралын явцад хүлэмжийн хий болох метан ялгаруулдаг. Нэмж дурдахад хүнсний хаягдалд агуулагддаг ургамлын шим тэжээл, органик бодис зэрэг үнэ цэнтэй нөөцийг дахин боловсруулж, ашиглах боломжгүйгээр хаядаг байна.

2020 онд НЗДТГ-аас "G9202-MON: Улаанбаатар хотын хүнсний хаягдлыг дахин боловсруулах төсөл"-ийг Ази, Номхон далайн бүсийн тогтвортой хөгжлийн Японы сангийн (JFPR) санхүүжилтээр Азийн хөгжлийн банк (АХБ) санаачлан хэрэгжүүлж байна. Энэхүү төслийн гол зорилго нь хүнсний хаягдлыг дахин боловсруулах замаар Улаанбаатар хотын хог хаягдлын үр дүнтэй менежментийг дэмжих явдал юм. Энэхүү төслийн хүрээнд туршилтын төслийг гурван түвшинд хэрэгжүүлэх ба хүнсний хаягдлаар компост хийх аргачлалуудыг ашиглах юм. Үүнд:

- Айл, өрхүүдэд хэрэгжүүлэх жижиг түвшний туршилт
- Сонгогдсон цэцэрлэг, сургууль, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, СӨХ-д хэрэгжүүлэх дунд түвшний туршилт
- Жилд 700 тонн хүнсний хаягдлыг боловсруулах том түвшний туршилт. Энэхүү туршилтын төслийн бүтээн байгуулалтыг 2023 онд дуусгахаар төлөвлөж байна.

Төсөлд мөн эдгээр туршилтын төслүүдийг цаашид өргөжүүлэх хөтөлбөр багтсан болно. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд хог хаягдлын менежменттэй холбоотой эрх зүйн зохицуулалт, бүтэц, зохион байгуулалтын тогтолцооны талаар цогц ойлголттой байх нь маш чухал юм.

2.2 Хамрах хүрээ, арга зүй

Туршилтын төслүүдийн цар хүрээг нэмэгдүүлэхэд шаардлагатай эрх зүйн зохицуулалт, зохион байгуулалтын тогтолцооны судалгаа хийх төслийн 3.7-р үйл ажиллагаа нь хоёр хэсгээс бүрдсэн ба энэхүү тайлан нь эхний хэсгийн тайлан болно.

1-р хэсэг нь хүнсний хаягдлын менежментийн өнөөгийн хууль эрх зүйн орчин, бодлого, хөтөлбөрүүдийн тоймоос бүрдэнэ. Энэ хүрээнд 2023 оны 3-р сарын байдлаар хэрэгжиж буй хууль тогтоомжийн үндсэн хэрэгсэл, бодлогын чиглэлийг тодорхойлов. Энэ нь 2-р хэсгийн тайлангийн лавлах баримт бичиг болох юм.

2-р хэсгийн судалгааг том түвшний туршилтын төсөл хэрэгжиж эхэлсний дараа буюу 2023 оны 4-р улирлаас хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөж байна. Энэ тайлан нь компостын систем, түүний байршил, үйл ажиллагааны зарчим, горим зэрэгтэй холбоо бүхий хууль эрх зүйн болон байгууллагын талаар мэдээллийг агуулна. Төслийн том түвшний туршилтыг өргөжүүлэх тодорхой зөвлөмжүүд нь том түвшний туршилтын төслийн явц, үр дүнтэй салшгүй холбоотой юм.

2.3 Тайлангийн зохион байгуулалт

Тайлан нь үндсэн найман бүлэгт хуваагдана.

- **Байгаль орчны хууль эрх зүйн орчин** – Үүнд, хог хаягдлыг хадгалах, цуглуулах, тээвэрлэх, сэргээн ашиглах (компост боловсруулах) болон устгахад тавигдах ерөнхий шаардлагуудыг нарийвчлан тусгасан болно.
- **Институцийн хүрээ** – Үүнд, Монгол Улсын засгийн газрын бүтэц, шатлал бүрд хамаарах эрх мэдлийн хуваарилалтыг нарийвчлан тусгасан.
- **Үндэсний хөгжлийн бодлого** - Үүнд, хог хаягдлын (хүнсний хаягдлыг оролцуулан) менежменттэй холбоо бүхий Монгол Улсын хөгжлийн бодлогын зорилго, зорилтуудыг нарийвчлан тодорхойлов.
- **Улаанбаатар хотын хөгжлийн бодлого** - Үүнд, Улаанбаатар хотын онцлогт тохирсон хог хаягдлын бодлогыг тодорхойллоо.
- **Хог хаягдлын тухай хууль тогтоомж, шаардлага** - Үүнд, хог хаягдал, түүний дотор хүнсний хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, боловсруулах, устгахтай холбоотой одоо хэрэгжиж байгаа журам, тавигддаг шаардлагыг нарийвчлан тусгасан болно.
- **Хог хаягдлын менежментийн дэд бүтэц** - Үүнд, хог хаягдлыг зохицуулах хууль тогтоомжийн шаардлагуудыг дараах байдлаар нарийвчлан тусгав:
 - Хадгалалт ба ангилан ялгалт
 - Цуглуулалт, ачилт
 - Тээвэрлэлт
 - Компост хийх замаар дахин боловсруулах
 - Устгах, булшлах
- **Хог хаягдлын менежментийн санхүүжилт ба төсөвлөлт** - Үүнд, хог хаягдлын менежментийн үйлчилгээнд зарцуулах төлбөр, хураамжийн талаар нарийвчлан тусгасан.
- **Хүнсний хаягдлын цогц менежментийн шинжилгээ** - Үүнд, хүнсний хаягдлыг хадгалах, цуглуулах, тээвэрлэх, бордоо хийх, хог хаягдлыг устгах үйл ажиллагааг хамарсан хууль тогтоомжийн үндсэн хэрэгслүүдийг нарийвчлан тусгасан болно.

3 Байгаль орчны эрх зүйн орчин

Хог хаягдлын менежментийг зохицуулдаг гол хууль нь Хог хаягдлын тухай хууль бөгөөд хог хаягдлыг хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах (компост болгох) болон устгахад тавигдах ерөнхий шаардлагыг тодорхойлсон. Одоогоор хүнсний хаягдлын менежменттэй холбоо бүхий тусгайлсан эрх зүйн бичиг баримт боловсруулагдаагүй байна. Иймд, Хог хаягдлын тухай хуульд хүнсний хаягдлыг энгийн хог хаягдлын бүрэлдэхүүн хэсэг гэж зохицуулсан байдаг. Үүнийг тайлангийн 3.1-т авч үзнэ.

Тайлангийн 3.2-т туршилтын төслүүдийг өргөжүүлэхэд анхаарах шаардлагатай байгаль орчны хууль тогтоомжийн холбогдох заалтуудыг нэгтгэн харуулав. Гэвч, хаягдалгүй, тойрог эдийн засаг, үйлдвэрлэгч, импортлогчийн өргөтгөсөн хариуцлагатай холбоо бүхий шаардлагууд эдгээр хуулиудад хангалттай тусгагдаагүй байгаа нь хууль, эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байгааг илтгэнэ.

3.1 Хог хаягдлын тухай хууль

Хог хаягдлын тухай бие даасан анхны хуулийг 2012 онд баталсан. 2012 оноос өмнө хог хаягдлын менежментийг бусад хуулиар зохицуулдаг байсан ба тухайлбал, Аюултай хог хаягдлын импорт, хилээр тээвэрлэхийг хориглох тухай хууль; Ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын тухай хууль (2003); Зарим гялгар уут хэрэглэхийг хориглох тухай хууль (2009) зэрэг хуулиудаар зохицуулдаг байв. Байгаль орчны хуулийн шинэчлэлийн хүрээнд дээрх гурван хуулийг нэгтгэж Хог хаягдлын тухай хуулийг 2012 онд батлав.

2017 онд УИХ-аар Хог хаягдлын тухай хуулийг шинэчилсэн найруулгыг баталсан болно. Энэ нь хог хаягдлын менежментийн дараах харилцааг зохицуулах зорилготой юм.

- Хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах
- Хог хаягдлын арилжааны хэрэглээг дэмжих замаар байгалийн нөөцийг хэмнэх
- Хог хаягдлын менежментийн талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг ангилан ялгах, багасгах, цуглуулах, тээвэрлэх, устгах, экспортлох үйл ажиллагааг дэмжих, болон
- Аюултай хог хаягдлыг хилээр нэвтрүүлэх, импортлохыг хориглох.

Мөн энэ хуулиар ахуйн болон аюултай хог хаягдал (хатуу, шингэн, хий), тухайлбал ахуйн болон аюултай хог хаягдлыг бууруулах, ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, устгах, экспортлох, импортлох, хилээр тээвэрлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна. Энэхүү хуулиар хог хаягдлын нэгдсэн менежментийн зохицуулалтыг хуульчилсан ба хэд хэдэн давуу талтай, үүнд:

- Төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг
- Цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, дахин ашиглах, устгах үйл ажиллагаа, тусгай зөвшөөрөлд тавигдах шаардлага
- Аюултай хог хаягдлын тухай тусгай журам
- Иргэд, аж ахуйн нэгжүүдийн хог хаягдлыг арилжааны зориулалтаар ашиглах, дахин боловсруулах явдлыг дэмжих
- Үйлдвэрлэгч/импортлогчдоос бараа бүтээгдэхүүний савлагааг дахин боловсруулахыг шаардах, мөн
- Хог хаягдлын талаар мэдлэг боловсролыг түгээн, дэмжих.

Хог хаягдлын тухай хуульд хүнсний хаягдлын талаар тухайлсан тодорхойлолт байхгүй бөгөөд үүнийг ахуйн хог хаягдлын нэг хэсэг гэж үздэг. Уг хуулийн холбогдох заалтуудыг ХАЙРЦАГ 1-ээс үзнэ үү.

ХАЙРЦАГ 1: ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХҮНСНИЙ ХАЯГДАЛТАЙ ХОЛБОГДОХ ЗААЛТУУД

Хог хаягдлын тухай хууль - 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

3.1. Энэ хуулиар дараахь хог хаягдалтай холбогдсон харилцааг зохицуулна:

3.1.1. энгийн хатуу хог хаягдал;

3.1.2. цацраг идэвхт хог хаягдлаас бусад хий, шингэн, хатуу төлөвт орших аюултай хог хаягдал

Хог хаягдлын тухай хууль - 4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1. "хог хаягдал" гэж өмчлөгч этгээд хэрэглэхгүй болсон эд юмс, материалыг;

4.1.2. "аюултай хог хаягдал" гэж тэсрэмтгий, шатамхай, урвалын идэвхтэй, исэлдүүлэгч, агаар болон устай харилцан үйлчилж хортой хий ялгаруулдаг, халдвартай, идэмхий, хүн амьтанд богино болон удаан хугацаанд хортой нөлөөлөл үзүүлдэг, байгаль орчинд хортой шинж чанартай, устгасны дараа аюултай шинж чанартай ялгарал үүсгэдэг хог хаягдлыг;

4.1.3. "энгийн хог хаягдал" гэж аюултай хог хаягдлаас бусад хог хаягдлыг;

4.1.4. "ахуйн хог хаягдал" гэж айл өрхөөс гарах энгийн хог хаягдлыг;

3.2 Байгаль орчны холбогдох хууль тогтоомж

Байгалийн баялаг, байгаль орчныг хамгаалах бодлого нь Монгол Улсын Үндсэн хуулийн 6.1 дэх хэсэгт байна:

"Газар, газрын хэвлий, ой, ус, ургамал, амьтан болон байгалийн бусад баялаг нийтийн өмч бөгөөд төрийн хамгаалалтад байна".

16.1.2-т дараахь зүйлийг заасан байдаг.

"Монгол Улсын иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах, байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцвэрт байдал алдагдахаас хамгаалагдах эрхийг эдэлнэ".

Монгол Улсын Засгийн газраас Үндсэн хуульд нийцсэн байгаль орчны хууль тогтоомжийн хэд хэдэн баримт бичиг, стандартыг баталсан бөгөөд одоогийн байдлаар 30 гаруй хууль, 150 гаруй стандарт хүчин төгөлдөр үйлчилж байна. Голлох хуулиудыг доор тайлбарлав.

Байгаль орчныг хамгаалах тухай хууль нь 1995 онд батлагдсан ба 2012 оны 5-р сард нэмэлт, өөрчлөлт оруулсан. Энэхүү хууль нь байгаль орчны менежментийн тогтвортой хөгжлийн зарчмуудын үндэс суурийг тавьсан, бусад хууль тогтоомжид заасан зарчим, шаардлагыг нарийвчлан тодорхойлсон цогц баримт бичиг юм. Энэ хуулийн зорилго нь:

"Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээлт хийх талаар төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсч буй асуудлыг зохицуулах, нийгэм, ирээдүй хойч үеийнхний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах"

Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль 2006 оны 5 дугаар сарын 25-ны өдөр батлагдсан энэ хуулиар химийн хорт бодис импортлох, экспортлох, хадгалах, ашиглах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулдаг. Мөн химийн хорт болон

аюултай бодис хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахыг талуудад үүрэг болгожээ.

Ургамал хамгаалах тухай хууль 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн энэ хуулийн зорилго нь бэлчээр, таримал ургамлыг өвчин, хортой шавж, мэрэгч, хогийн ургамлаас хамгаалах, хянах, хорио цээрийн дэглэм тогтоох, хяналт тавихтай холбогдсон төр, иргэн, хуулийн этгээд хоорондын харилцааг зохицуулахад оршино.

Усны тухай хууль нь 1995 оны 6 дугаар сард батлагсан бөгөөд 2012 оны 5 дугаар сард өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан. Уг хуульд хог хаягдалтай холбоотой заалт, тухайлбал, усны нөөцийн бүсэд цацраг идэвхт болон химийн хаягдлыг байршуулахыг хориглох, усны нөөцийн бүсэд машин болон бусад бохирдсон зүйлсийг угаасны дараа бохир ус нийлүүлэх, хог хаягдлыг булшлах, хадгалахыг хориглосон заалт орсон.

Агаарын тухай хууль 1995 оны 6 дугаар сард батлагдаж, 2012 оны 5 дугаар сард шинэчлэгдсэн. Энэ хуульд хог хаягдлын бүх төрлийн шатаалтаас агаарт ялгарах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоох талаар зохицуулалт орсон. Хуулиар тогтоосон утааны хэмжээ зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд байгаль орчны байцаагч үйл ажиллагааг нь зогсоох тухай заалт уг хуульд бий. Олон улсын стандартын дагуу баригдсан шинэ байгууламжид агаарын ялгарлыг хянах систем, хүлэмжийн хийг бууруулах технологийг ашиглах шаардлагатай. Мөн энэ хуульд агаар мандалд ялгарах хорт хийнээс хамаарсан төлбөрийн системийг санал болгосон байдаг. **Агаарын төлбөрийн тухай хуульд** эдгээр хураамжийн талаар дэлгэрэнгүй заасан байдаг.

Тусгай зөвшөөрлийн тухай хууль 2001 онд батлагдсан бөгөөд уг хуулиар зөвшөөрөгдөх хэмжээг тогтоох боломжгүй бохирдуулагч бодисыг ялгаруулах үйл ажиллагааг эрхлэгч нь тусгай зөвшөөрөл авах талаар шаардлагыг тогтоож өгсөн. Мөн байгаль орчинд ноцтой хохирол учруулж болзошгүй химийн бодисын импорт, худалдаа, химийн бодис хэрэглэдэг аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд тусгай зөвшөөрлийг энэ хуулиар олгох юм.

Хот байгуулалтын тухай хууль нь 2008 онд батлагдсан бөгөөд хүн амын суурьшил, бүс нутгийн хөгжил, хот, тосгоныг хөгжүүлэх зохистой бүтцийг бий болгох чиглэлээр төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хоорондын харилцааг зохицуулдаг. Хот, тосгоны нутаг дэвсгэрийн бүсчлэлийг хот байгуулалтын норм, стандарт, дүрэм, журмын дагуу төлөвлөх зохицуулалтыг тусгасан байдаг ба хог хаягдлын төвлөрсөн цэг нь тусгай зориулалтын бүсэд хамаардаг.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль 2012 онд батлагдсан. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2 дахь заалтыг хэрэгжүүлэхэд оршино.

“Байгаль орчныг хамгаалах, хүний буруутай үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас урьдчилан сэргийлэх, байгалийн нөөцийг байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар ашиглах, бүс нутаг, салбарын бодлогыг хэрэгжүүлэх үндсэн зорилготой. Энэхүү хуулиар аливаа төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхдээ төслийн байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлж, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулдаг.”

3.3 Журам

Хог хаягдлын тухай хуулийн дагуу энгийн хог хаягдлын (хүнсний хаягдлыг оролцуулан) менежменттэй холбоотой дараах журам, тогтоол, зааврууд батлагдсан байна. Тэдгээр нь:

- **Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/444 дүгээр тушаал** (2018.11.19). “Энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булах үйл ажиллагаа эрхэлдэг этгээдийн бүртгэлийн загвар”, “Энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, дахин ашиглах, шатаах, устгах, булах үйл ажиллагааны тайлангийн загвар”.
- **Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан А 429/257 дугаар тушаал** (2018.11.13). “Хог хаягдлын талаар үйлдвэрлэгч, импортлогчийн хариуцах бүтээгдэхүүний жагсаалт”
- **Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/349 дүгээр тушаал** “Эх үүсвэрт үүссэн хог хаягдлын кодлогдсон жагсаалт, түүний ангилал, зэрэглэл”
- **Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын А/428 дугаар тушаал** (2018.11.12). “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”
- **Нийслэлийн ИТХ-ын 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 32/03 дугаар тогтоол** “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, дахин ашиглах, устгах, булах журам”

3.4 Стандартууд

Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Стандарт, хэмжил зүйн газар MSN стандартыг боловсруулж, батлуулах үүрэгтэй. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хууль 2017 онд батлагдсан бөгөөд Энэ хуулийн зорилго нь стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн эрх зүйн үндсийг тогтоож, бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээ, менежментийн тогтолцооны чанар, аюулгүй байдлыг хангах, хэрэглэгч, үйлдвэрлэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино

Хүснэгт 1 -д ахуйн хог хаягдал (хүнсний хаягдлын оруулан) болон компостод хамаарах стандартуудыг жагсаав.

Хүснэгт 1 : Ахуйн хог хаягдал, компосттой холбоотой стандартууд

№	Стандарт
1	MNS 5344: 2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага
2	MNS 0017-2-0-07: 1979. Хог хаягдлаас үүсэх агаарын бохирдол. Ангилал
3	MNS 0017-2-1-17: 1980. Агаарын орон зай. Агаар бохирдуулагч үйлдвэрлэлийн хог хаягдал, бохирдол
4	MNS 3383: 1982. Агаарын орон зай. Бохирдлын эх үүсвэрүүд. Нэр томьёо ба тодорхойлолт
5	MNS 6507: 2015. Компост. Техникийн шаардлага
6	MNS 6818: 2020. Органик хуурай компост. Органик бүрэлдэхүүнийг тодорхойлох исэлдлийн арга
7	MNS 6252: 2011. Мод үржүүлгийн бордооны хэрэглээ

4 Байгууллагын бүтэц, тогтолцоо

Энэ бүлэгт Монгол Улсын Засгийн газар болон орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, эрх үүргийн хэм хэмжээг тусгасан болно.

4.1 Засгийн газрын бүтэц

Монгол Улс дөрвөн шатлалтай төрийн засаглалын тогтолцоотой нэгдмэл улс юм.

1-р шатлал: Төв засгийн газар .

- Улсын Их Хурал - хууль тогтоох эрх бүхий төрийн эрх барих дээд байгууллага
- Засгийн газар, яамд - Монгол улсын төрийн гүйцэтгэх байгууллага
- Дээд шүүх - шүүхийн дээд байгууллага

2-р шат: Аймаг, Нийслэл.

- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба

Гуравдугаар шат: Сум, дүүрэг.

- Дүүргийн Иргэлийн Төлөөлөгчдийн хурал
- Дүүргийн Засаг даргын Тамгын газар

4-р шат: Баг, хороо. (Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хамгийн доод нэгж):

- Хорооны Иргэдийн хурал
- Хорооны Засаг дарга

4.2 Байгууллагын эрх, үүрэг

Энэ хэсэгт хүнсний хаягдлыг дахин боловсруулах хууль эрх зүйн орчинтой холбоотой одоо байгаа байгууллагын эрх, үүргийг (давуу тал болон хязгаарлалт) тоймлон харуулав.

Монгол Улсын Их Хурал:

- хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас зохион байгуулж байгаа ажилд хяналт тавих;
- Засгийн газраас өргөн мэдүүлснээр хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийг баталж, зарцуулалтад хяналт тавих;

Монгол Улсын Засгийн газар:

- аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам батлах;
- аюултай хог хаягдлын жагсаалт батлах;
- Монгол Улсад импортлохыг хязгаарласан болон хориглосон зарим хог хаягдлын жагсаалт батлах;
- хууль тогтоомжид заасан бусад.

Байгаль орчин, аялал жуулчлалын яам:

- хог хаягдлын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангах;
- хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг хангах;
- хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журмыг батлах;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 1.5-д заасан зөвшөөрлийг аж ахуйн нэгж, байгууллагад олгох; (Энэ заалтад 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн хуулиар өөрчлөлт оруулсан)
- эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэлийг батлах;
- энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх;
- энгийн хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, шатаах, устгах, булшлах үйл ажиллагааны тайлангийн маягт
- энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлагыг батлах;
- энгийн хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх;
- энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлалыг батлах;
- хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан зааврыг батлах;
- үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалтыг төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах.
- хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийг төлөвлөх, төслийн санал гаргах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний хэрэгжилтийг хангах, хяналт тавих.
- Хог хаягдлын норм тогтоох аргачлал батлах;
- Хатуу хог хаягдлын менежментийн үндэсний мэдээллийн сан бүрдүүлэх журмыг боловсруулж, батлах.

Сангийн яам:

- хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтийг хангуулах;
- энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран батлах;
- хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйл ажиллагааг дэмжих чиглэлээр бодлого боловсруулах.

Эрчим хүчний яам, эрчим хүчний зохицуулах хороо

- эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдалд хяналт тавих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;
- хог хаягдлыг сэргээн ашиглах үйл ажиллагаанаас гарган авсан эрчим хүчний үнийн тооцоог хянах, тарифыг батлах.

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

- нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;
- хог хаягдлын менежментийг сайжруулах орон нутгийн хөтөлбөрийг баталж, биелэлтэд хяналт тавих;
- энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журмыг баталж, мөрдүүлэх;
- нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булшлах зардлын нэгж тарифыг батлах;
- Хог хаягдлын тухай хуулийн 40.4-т заасан урамшуулал олгох журмыг батлах

Нийслэлийн Засаг дарга:

- хог хаягдлын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;
- хог хаягдлын менежментийг сайжруулах орон нутгийн хөтөлбөрийн биелэлтийг хангах;
- хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт, шалгалтыг нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;
- төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр, олон улсын зээл, тусламжаар байгуулсан хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, булшлах, устгах байгууламжийн үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулах;
- хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах зорилгоор ангилан ялгах, дахивар нөөц цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг зохион байгуулж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
- хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журмыг батлах;
- хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх хүрээнд төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх төслийг төлөвлөх, төслийн санал гаргах, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээний хэрэгжилтийг хангах, хяналт тавих.

Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал

- энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифыг батлах;
- тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох.

Дүүргийн Засаг дарга:

- Хог хаягдлын тухай хууль тогтоомжийг дүүргийнхээ хэмжээнд хэрэгжүүлэх;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу хуулийн этгээдтэй хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх гэрээ байгуулах;
- Авто замын болон ойр орчмын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх ажлыг зохион байгуулах;
- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, булах зэрэгт хог хаягдлын үйлчилгээний хөлсөөр хуримтлагдсан орлогыг зарцуулах;
- Нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулна
- Хог хаягдлын талаарх боловсрол олгох сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, дэмжих, сурталчлах;
- Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хог хаягдлын менежментийн олон нийтийн байцаагчийг ажиллуулах;
- Иргэн, хуулийн этгээдээс хог хаягдлын үйлчилгээний төлбөр хураалтад хяналт тавих;
- Хог хаягдлын үйлчилгээний төлбөрийн орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ

Үйл ажиллагаа 3.7. Туршилтын төслүүдийн цар хүрээг нэмэгдүүлэх хууль, эрх зүй болон байгууллагын тогтолцооны судалгаа

- Хог хаягдалтай холбоотой олон нийтийн бүлгүүдийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх;
- Нийтийн эзэмшлийн талбайд хангалттай тооны хогийн сав байрлуулах
- Хуулийн этгээдийн орчмын нийтийн эзэмшлийн талбайн 50 м-ийн хилийн бүсийг тухайн нутаг дэвсгэрийн хог хаягдал, цасыг цэвэрлэх зорилгоор тогтоох;
- Хог хаягдлын хамрах хүрээг хязгаарлах, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг ийм нөлөөлөл, эрсдэлтэй нөхцөлд зохион байгуулах; болон
- Олон нийтийн байцаагчдад олгох урамшууллын хэмжээг тодорхойлж, жилийн төсвөөр батлуулах.

Хорооны Засаг дарга:

- нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;
- хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах;
- иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөлтөд хяналт тавих;
- хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;
- хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих;
- хог хаягдлын талаархи олон нийтийн боловсролыг дээшлүүлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах;
- хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилга гаргах, зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус иргэдийн бүлэг байгуулж ажиллуулах.

Оператор компаниуд:

Хууль заасан чиг, үүргээс гадна хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэдэг төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд хог хаягдлын менежментэд томоохон үүрэг гүйцэтгэдэг.

Төрийн болон хувийн өмчит ТҮК (хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх компаниуд) нь дүүргийн Засаг дарга нартай дараах үйл ажиллагааг гүйцэтгэхээр гэрээ байгуулдаг. Үүнд:

- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх;
- Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн цэвэрлэгээ.

УБЦТС ТӨХК нь Нийслэл, дүүргийн Засаг даргатай дараах ажлыг гүйцэтгэхээр гэрээ байгуулдаг.

- Гэр хорооны айл өрхийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг цахилгааны төлбөртэй хамтатган цуглуулах.

5 Үндэсний хөгжлийн бодлого

Энэ бүлэгт хог хаягдлын (цаашид хүнсний хаягдал гэж ойлгоно) менежменттэй холбоотой Монгол Улсын хөгжлийн бодлогын талаар тайлбарлана.

5.1 Монгол Улсын хөгжлийн бодлого

Монгол Улсын Их Хурлаас 2020 оны 5-р сарын 7-нд **Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг баталж**, уг хуулиар хөгжлийн бодлого төлөвлөлтийн тогтвортой байдал, залгамж чанарыг хадгалах зарчмыг тодорхойлсон. Энэхүү хуулиар Монгол Улсыг урт хугацаанд (30 жил) хөгжүүлэх бодлогын нэг баримт бичигтэй байх талаар заасан байдаг.

Энэ хуулийн дагуу УИХ-аас 2020 оны тавдугаар сарын 13-ны өдөр **“Алсын хараа-2050”** хөгжлийн урт хугацааны бодлогын баримт бичгийг баталсан болно. УИХ-ын тогтоолоор батлагдсан "Алсын хараа-2050" баримт бичиг нь зорилт, зорилго, хэрэгжүүлэх арга хэмжээ, хяналт-шинжилгээ, шалгуур үзүүлэлт зэрэг бүрэлдэхүүн хэсэгтэй юм.

“Алсын хараа-2050” нь Үндэсний эв нэгдэл, Хүний хөгжил, Амьдралын чанар, Дундаж орлоготой хүн ам, Эдийн засаг, Засаглал, Ногоон хөгжил, Аюулгүй нийгэм, Бүс нутаг, орон нутгийн хөгжил, Улаанбаатар, дагуул хот зэрэг есөн зорилтын хүрээнд хөгжлийн 47 зорилгыг тодорхойлсон болно.

“Алсын хараа-2050”-д тусгагдсан есөн зорилт, 47 зорилгоос гурван зорилт, таван зорилго нь хог хаягдлын салбартай холбоотой бөгөөд нийт 30 арга хэмжээ багтсан байна. (Хайрцаг 2-оос үзнэ үү).

Хог хаягдлын салбарын хяналт үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшингийн харьцуулалтыг **Зураг 1**-т үзүүллээ.

Зураг 1: Хог хаягдлын үзүүлэлт, хүрэх түвшин - “Алсын хараа-2050”



ХАЙРЦАГ 2: “АЛСЫН ХАРАА-2050” ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГАА

ХОЁРДУГААР ЗОРИЛГО: ХҮНИЙ ХӨГЖИЛ

Зорилт 2.5: Хүнд ээлтэй амьдрах орчин. Амьдралын бүхий л хэрэгцээг хангасан, эрүүл, тав тухтай орчныг бүрдүүлж, баталгаат хүнсээр хангана.

2.5.10. Хог хаягдлын цогц менежментийн 3R системийг хэрэгжүүлж, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэнд оруулах, дахин боловсруулах, дахин ашиглах загвар төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, ногоон байгууламж бүхий талбайг нэмэгдүүлнэ.

2.5.1. Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламж болон бусад хот, суурин газрын ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийг байгаль орчинд ээлтэй, дэвшилтэт технологид нийцүүлэн өргөтгөн шинэчилнэ.

ЗУРГААДУГААР ЗОРИЛГО: НОГООН ХӨГЖИЛ

Зорилт 6.3: Ус - үнэт баялаг. Усны нөөцийн хомсдолоос урьдчилан сэргийлж, гадаргын ус хуримтлагдах нөхцөлийг бүрдүүлж, хангамжийг нэмэгдүүлнэ.

6.3.3. Ус бохирдуулсны төлбөр, ус ашиглалтын тусгай зөвшөөрөл олгох замаар үйлдвэрийн усны дахин боловсруулалт, үр ашгийг дээшлүүлж, усны ашиглалтаас үүсэх бохирдлыг бууруулна.

6.3.4. Бохир усыг дахин боловсруулах, дахин боловсруулсан усыг ашиглахыг дэмжинэ

Зорилт 6.4: Нүүрстөрөгчийн ялгарал багатай, хүртээмжтэй, ногоон хөгжил. Нүүрстөрөгч багатай хүртээмжтэй, бүтээмжтэй ногоон эдийн засгийг хөгжүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах олон улсын хүчин чармайлтад хувь нэмрээ оруулна.

6.4.2. Хог хаягдлыг бууруулах, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэнд оруулахад чиглэсэн эко төлбөрийн эрх зүйн зохицуулалтыг бий болгож, хэрэгжүүлнэ.

6.4.4. Бохирдол, хог хаягдлыг бууруулах, нөөцийн хэмнэлттэй байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, цэвэр үйлдвэрлэл, хэмнэлттэй хэрэглээг эдийн засгийн хөшүүргээр дэмжинэ.

6.4.7. Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлж, Монгол Улсын үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн хэрэгжилтийг хангаж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлж, эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, зам тээвэр, үйлдвэрлэл, хог хаягдлын салбараас ялгарах хүлэмжийн хийг бууруулна.

6.4.9. Салбаруудын хүлэмжийн хийн ялгарлыг хэмжих, тооцоолох, тооллого хийх, магадлах, тайлагнах чадавхыг бий болгон бэхжүүлж, цахимжуулна

6.4.17. Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, хог хаягдлыг бууруулах, нөөцийн ашиглалтын үр ашгийг дээшлүүлэх чиглэлээр ногоон төсөл, хөтөлбөрүүдийг НҮБ-ын Уур амьсгалын ногоон сан болон олон улсын санхүүгийн бусад механизмаар дамжуулан хэрэгжүүлнэ.

6.4.19. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, дахин боловсруулах, байгаль орчинд сөрөг нөлөөгүй эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрүүдийг байгуулна .

6.4.20. Улаанбаатар хот, бүсийн төвүүд болон бусад хот, суурин газарт хог хаягдлын төвлөрсөн цэгийн стандартын лансфиллын байгууламж, аюултай хог хаягдлыг түр хадгалах, устгах зориулалтын байгууламжийг үе шаттайгаар байгуулна .

6.4.21. Барилга, зам, тээврийн салбарын хатуу хог хаягдлыг байгаль орчинд ээлтэй технологи ашиглан устгаж, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.

6.4.23. Цэвэрлэх байгууламж, гэр хорооллын жорлонгийн лагийг байгаль орчинд ээлтэй аргаар устгах туршилтын төслийг хэрэгжүүлж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.

ЕСДҮГЭЭР ЗОРИЛГО: УЛААНБААТАР, ДАГУУЛ ХОТ

Зорилт 9.2: Байгаль орчинд суурилсан шийдэл. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлж, экосистемийн тэнцвэрт байдлыг хангасан, хүлэмжийн хийн ялгарал багатай ногоон технологи бүхий амьдралын таатай орчинтой хот болно.

9.2.22. Хаягдал лаг, тунадсыг боловсруулан эцсийн бүтээгдэхүүн болгох, цэвэрлэгдсэн усыг боловсруулж дахин давтан ашиглах эрх зүйн орчныг бүрдүүлж, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, эргүүлэн ашиглах гол шугам сүлжээ төслийг хэрэгжүүлнэ.

9.2.25. Айл өрхийн нүхэн жорлон болон хүний буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй бохирдолд байгаль орчны нэгдсэн дүгнэлт хийж, байгаль орчин бохирдуулсны нөхөн төлбөр тооцох эрх зүйн орчныг бүрдүүлж гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг стандартад нийцүүлэх ажлыг үе шаттай зохион байгуулна.

9.2.26. Айл өрхүүдийн стандартын бус ариун цэврийн байгууламжийг шинэчлэх, ялгадсыг компост бордоо болгож эдийн засгийн эргэлтэд оруулна

9.2.27. Бохирдол бага ялгаруулах, хог хаягдалгүй хэрэглээг нэмэгдүүлэхэд захиргааны болон урамшууллын аргыг хослуулан хэрэглэнэ.

9.2.28. Ахуйн хэрэглээний болон цахилгаан станцуудаас гарах үнс, лаг, хог хаягдлыг дахин ашиглаж, хоёрдогч бүтээгдэхүүн үйлдвэрлэнэ.

9.2.29. Хог хаягдлыг ангилан ачих, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж, стандартыг бий болгох, дахин боловсруулах үйлдвэрт шилжүүлэх, хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийг цэвэрлэж, нөхөн сэргээнэ.

9.2.32. Нарангийн энгэр, Цагаан давааны хогийн цэгүүдийг хааж, нөхөн сэргээнэ.

5.2 Монгол Улсын эдийн засгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

Монгол Улсын **Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд** Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг нь дэвшүүлсэн зорилго, зорилтоо хангахад чиглэгдсэн, харилцан уялдаа бүхий дунд хугацааны буюу таван жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг байх бөгөөд Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл байна гэж заасны дагуу **Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл баримт бичгийг** баталсан байна. Энэхүү баримт бичгийн хог хаягдлын салбартай холбоотой үйл ажиллагаануудыг (**ХАЙРЦАГ 3**) үзүүлэв.

ХАЙРЦАГ 3: МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

ЗУРГАА: НОГООН ХӨГЖИЛ

Зорилт 6.4. Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, байгаль орчинд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай цэвэр технологи нэвтрүүлж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулж, дасан зохицох үндэсний чадавхийг бэхжүүлнэ.

6.4.4. Хүлэмжийн хийг 12.3%-иар бууруулна

6.4.6. Хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг 27%-д хүрнэ .

6.4.7. Аймгуудын төвүүдэд хог хаягдлын асуудлыг шийдэж, дахин боловсруулах үйлдвэр байгуулна.

ЕСӨН: УЛААНБААТАР, ДАГУУЛ ХОТ

Зорилт 9.2. Байгаль орчинд суурилсан шийдэл. Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, нөхөн сэргээх, хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгох

9.2.2. Хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээний технологийн шинэчлэл хийж, бохирдол багатай, хог хаягдалгүй хэрэглээг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ

5.3 Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр

Монгол улсын урт болон дунд хугацааны хөгжлийн бодлого дээр тулгуурлан “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г баталж шаардагдах хөрөнгийг жил бүрийн улс, орон нутгийн төсөв, гадаад зээл, тусламж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гаргахаар шийдвэрлэсэн.

Үйл ажиллагааны хөтөлбөрт хөгжлийн зургаан үндсэн зорилтыг тусгасан байна. Үүнд:

- Ковид-19 тахлын улмаас үүссэн нийгэм, эдийн засгийн хүндрэлийг даван туулах,
- Хүний хөгжил,
- Эдийн засаг,
- Ногоон хөгжил,
- Засаглал,
- Нийслэл ба, бүс нутаг, орон нутгийн хөгжил.

Эдгээрийг 23 тэргүүлэх зорилт, 259 зорилт, 1087 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасан. Хог хаягдлын салбартай холбоотой эдгээр арга хэмжээг **Хайрцаг 4-өөс** үзнэ үү.

ХАЙРЦАГ 4: 2020-2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХҮНСНИЙ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТТЭЙ ХОЛБОГДОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

ТАВ: НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

5.1.4. Гэр хороолол, аялал жуулчлалын бүсэд “Эко жорлон” төслийг хэрэгжүүлж, хөрсний бохирдлыг бууруулна.

5.1.9. Байгаль орчинд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээ, үйлдвэрлэлийг дэмжиж, эрчим хүч үйлдвэрлэх, аюултай хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийг байгуулна.

5.1.12. Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицох, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг 12.3%-иар бууруулна.

ЗУРГАА: НИЙСЛЭЛ, БҮС, ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН БОДЛОГО

6.1.9. Хог хаягдлын менежментийг сайжруулж, гэр хорооллын айл өрхүүдийг зориулалтын үнс хадгалах савтай болгож, дахин боловсруулах бүх төрлийн үйлдвэр байгуулна.

6.2.10. Аймаг, сумын төвийн хог хаягдлын асуудлыг шийдвэрлэж, хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдийг үе шаттайгаар байгуулна

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 12-р сарын 9-ний өдрийн 203 дугаар тогтоолоор үйл ажиллагааны хөтөлбөр, түүнд тавих хяналт, шинжилгээ, үнэлгээний тогтолцоо, шалгуур үзүүлэлт, зорилтыг баталсан. Хог хаягдлын салбарын хувьд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

- **“Хүнсний хаягдлыг дахин боловсруулах төсөл”-ийг Ази, Номхон далайн бүсийн тогтвортой хөгжлийн Японы сангийн (JFPR) санхүүжилтээр Азийн Хөгжлийн Банктай (АХБ) хамтран хэрэгжүүлнэ.**
- Төвлөрсөн хогийн цэгүүдийн нөхцөлийг сайжруулж, олон жил ашигласан хогийн цэгүүдийг хааж, нөхөн сэргээлт хийнэ.
- Европын сэргээн босголт, хөгжлийн банкны (ЕСБХБ) зээл, буцалтгүй тусламжаар Морин давааны хогийн цэгт шинэ хогийн цэг, барилгын хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр барих төслийг үргэлжлүүлнэ.
- Цагаан давааны хогийн цэгт хоногт 300 тн хог хаягдал ангилах хүчин чадалтай үйлдвэр байгуулна.
- Швейцарийн хөгжлийн корпорацийн санхүүжилтээр Улаанбаатар хотын ахуйн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх менежментийн төслийг хэрэгжүүлнэ.
- Улаанбаатар хотын хог хаягдлыг дахин боловсруулах төсөл (3г4ub төсөл) хэрэгжүүлнэ.
- Европын холбооноос хэрэгжүүлж буй SWITCH Asia 2 хөтөлбөрийн хүрээнд Монголд хуванцар хаягдлыг дахин боловсруулалтыг тогтвортой байдал төслийг хэрэгжүүлнэ.
- Төвлөрсөн хогийн цэгүүдийг ангилалыг дээшлүүлэн, хогийн цэгийн үйл ажиллагаа, технологийг сайжруулах арга хэмжээг найман аймагт авч хэрэгжүүлнэ.
- Хог хаягдлыг дахин боловсруулах эко парк төсөл хэрэгжүүлнэ.

6 Улаанбаатар хотын хөгжлийн бодлого

Энэ бүлэгт Улаанбаатар хотын онцлогт тохирсон хог хаягдлын салбарын хөгжлийн бодлогын талаар тайлбарлана.

Нийслэлийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 02/09 дүгээр тогтоолоор **Нийслэл Улаанбаатар хотыг 2021-2025 он хүртэл хөгжүүлэх үндсэн чиглэлийг баталсан**. Энэхүү үндсэн чиглэлийн “Ногоон хөгжил” 6 дугаар бүлэгт Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгасан байна. (**ХАЙРЦАГ 5**).

ХАЙРЦАГ 5: УЛААНБААТАР ХОТЫГ 2021 - 2025 ОНУУДАД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ

ЗОРИЛГО 6. НОГООН ХӨГЖИЛ

Зорилт 6.2. Байгаль орчны бохирдлыг бууруулж, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулна.

6.2.3. Хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах, тээвэрлэх дэвшилтэт цогц арга, технологи нэвтрүүлж, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин төвлөрсөн цэгт булшлах хог хаягдлын хэмжээг бууруулна.

6.2.4. Төвлөрсөн хогийн цэгүүдийн нөхцөлийг сайжруулж, хуучин хогийн цэгүүдийг үе шаттайгаар хааж, нөхөн сэргээнэ.

6.2.5. Хог хаягдлын үйлчилгээний хураамж төлөх нээлттэй, ил тод, хялбаршуулсан цахим системийг нэвтрүүлнэ.

6.2.7. Гэр хорооллын айл өрхүүдийг эдийн засгийн хувьд дэмжих замаар стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлж, байгаль орчинд ээлтэй аргаар тээвэрлэж, устгадаг технологийг шат дараатай нэвтрүүлнэ.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг НИТХ -ын 2020 оны 12-р сарын 4-ний өдрийн 02/10 дугаар тогтоолоор баталж, нийслэлийн хөрсний бохирдлыг бууруулах, хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр дараах үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэхээр тусгасан байна. (**ХАЙРЦАГ 6**).

ХАЙРЦАГ 6: НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА, УЛААНБААТАР ХОТЫН ДАРГЫН 2020 - 2024 ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР

5.2.7. Хог хаягдлыг ангилах, боловсруулах байгууламжийг дэмжихэд иргэд, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлж, цогц бодлого хэрэгжүүлнэ.

5.2.7.1. Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх дэвшилтэт, иж бүрэн технологи нэвтрүүлж, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих замаар булшлах хог хаягдлын хэмжээг бууруулна .

5.2.7.2. Төвлөрсөн хогийн цэгүүдийн нөхцөлийг сайжруулж, хуучин хогийн цэгүүдийг үе шаттайгаар хааж, хэсэгчлэн нөхөн сэргээнэ.

5.2.7.3. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төлөх нээлттэй, ил тод, хялбаршуулсан цахим системийг нэвтрүүлнэ.

5.2.7.4. Аюултай хог хаягдлыг бүртгэлжүүлж, ангилан ялгаж тээвэрлэх, түр хадгалах, саармагжуулах, устгах тогтолцоог бүрдүүлнэ.

5.2.8. Хүнсний хаягдлыг боловсруулж, өдөрт 2000 кг компост үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр байгуулна

7 Хог хаягдлын менежменттэй холбоотой хууль эрх зүй, тавигдах шаардлага

Энэ бүлэгт хог хаягдал, түүний дотор хүнсний хаягдлыг цуглуулах, боловсруулах, устгахтай холбоотой одоогийн хууль тогтоомж, шаардлагыг нарийвчлан тусгасан болно.

7.1 Хог хаягдал булшлах (ландфил)

Хог хаягдлыг зөвхөн төлөвлөсөн болон зөвшөөрөгдсөн газарт хүлээн авах шаардлагатай бөгөөд байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйл тохиолдсон нөхцөлд УБЗАА-тай зөвшилцсөний үндсэн дээр нөөц талбайд хогийг хүлээн авч болно.

Хог хаягдлын төвлөрсөн цэгийн менежментийн хувьд **ХАЙРЦАГ 7**-д заасан шалгууруудыг нэвтрүүлсэн байх шаардлагатай.

Мөн хог хаягдлын төвлөрсөн цэг нь тээврийн хэрэгслийн улсын дугаар таних программ хангамж бүхий хяналтын камер, гадна, доторх хяналтын камер, компьютерийн программ хангамж бүхий цахим жин, бүхий бүртгэлийн байр, дугуй угаагч төхөөрөмжтэй байх шаардлагатай.

ХАЙРЦАГ 7: ТӨВЛӨРСӨН ЦЭГИЙН МЕНЕЖМЕНТЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- Нэг болон хоёрдугаар зэрэглэлийн хогийн цэгүүдэд өдөр бүр хогийг нягтруулж, хөрсөөр хучина. Гуравдугаар зэрэглэлийн төвлөрсөн цэгүүдэд долоо хоногт гурваас доошгүй удаа хөрсөөр хучиж, нягтруулах бөгөөд энэ тохиолдолд хөрсөн бүрхэвчийн зузаан нь 15 см-ээс багагүй байна.
- Цаг агаарын хэт хуурай, халуун, салхи, шуургатай үед хог хаягдлыг салхинд хийсгэх, агаарт тоосонцор үүсэхээс сэргийлж, хог хүлээн авах талбайг усаар чийгшүүлнэ.
- Гал түймэр гарсан тохиолдолд ус шүрших төхөөрөмжтэй усны машинтай байна. Гал түймэртэй тэмцэх бүх ажилтнууд зохих сургалтад хамрагдсан байна.
- Хог хаягдлын төвлөрсөн цэгт ашиглах машин, тоног төхөөрөмж нь олон улсын болон үндэсний стандартад нийцсэн байна.
- Хог хаягдлыг тээвэрлэж ирж буй тээврийн хэрэгслийг хог хаягдлын төвлөрсөн цэгийн бүртгэлийн байранд жинлүүлж, бүртгүүлнэ. Хог хаягдлын эх үүсвэр, төрлийг тодорхойлж, шаардлагатай тохиолдолд биологи, химийн болон аюултай, шатамхай, тэсэрч дэлбэрэх аюултай хог хаягдлыг төвлөрсөн цэгт нэвтрүүлэхгүй байх зорилгоор тээвэрлэж буй хог хаягдлыг хянан шалгана.
- Хог хаягдлын төвлөрсөн цэгт шингэн хог хаягдал, хүний цогцос, эд эрхтэн, тэсэрч дэлбэрэх бодис, химийн болон аюултай хог хаягдлыг булшлахыг хориглоно.
- Төвлөрсөн цэгийн үйл ажиллагаанаас агаар, хөрс, усны бохирдолд жилд нэг удаа хяналт тавиж, шинжилгээ хийнэ. Бохирдлын хэмжээ стандартаас хэтэрсэн тохиолдолд шалтгааныг тогтоож, хэвийн хэмжээнд хүрэх хүртэл арга хэмжээг авна. Бохирдлын хэмжээ стандартаас хэтэрсэн тохиолдолд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба бохирдлын хэмжээг зөвшөөрөгдөх хэмжээнд буурах хүртэл төвлөрсөн цэгийн үйл ажиллагааг түр хаана.

7.2 Хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах

Хог хаягдлын тухай хуулийн 8.1.9.б-д заасны дагуу бүртгэлтэй, хуулийн 9.3.2-т заасан зөвшөөрөл авсан хуулийн этгээд хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагааг эрхэлнэ. Мөн нийслэлийн хог хаягдлын менежмент, хяналтын нэгдсэн цахим системд бүртгүүлнэ. (1.6-д заасан).

Байгаль орчин хамгаалах тухай хуулийн 7-р бүлэгт заасны хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагаанд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэнэ.

Хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүд дүүргийн Засаг даргын зарласан сонгон шалгаруулалтад (Хог хаягдлын тухай хуулийн 2.4.7-д заасан) оролцож, гэрээ байгуулсан хог цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ эрхлэгчээр дамжуулан дахивар хаягдлаа цуглуулах, тээвэрлэх боломжтой.

Газрын тухай хууль болон холбогдох бусад хуулийн дагуу хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж буй аж ахуйн нэгжүүдэд газар ашиглалт, дэд бүтцийг бий болгоход дэмжлэг үзүүлэх заалтууд орсон байдаг.

Хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах үйл ажиллагаанд тавигдах нэмэлт нэмэлт шаардлагуудыг **ХАЙРЦАГ 8**-д үзүүлэв.

ХАЙРЦАГ 8: ХОГ ХАЯГДЛЫГ ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН АШИГЛАХ КОМПАНИУДАД ТАВИГДАХ НЭМЭЛТ ШААРДЛАГА

- Хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах технологи нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байх.
- Хог хаягдлыг дахин боловсруулсан, сэргээн ашигласан эцсийн бүтээгдэхүүн нь үндэсний болон олон улсын стандарт, шаардлагад нийцсэн байхаас гадна байгаль орчин, хүний эрүүл мэнд, ургамал, амьтанд сөрөг нөлөөгүй байх.
- Хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах үйлдвэрүүд нь Хог хаягдлын тухай хууль, холбогдох журам, дүрэм, стандарт, шаардлага, хөдөлмөр, эрүүл ахуйн аюулгүй байдал, сэргээн ашиглах болон дахин боловсруулах технологийн талаар ажилчдын дунд сургалт зохион байгуулах.
- Компаниуд тоног төхөөрөмж, машин механизмын ашиглалт, аюулгүй ажиллагаа, тэдгээрийн засвар үйлчилгээний талаархи гарын авлагааг боловсруулах.
- Байгалийн гамшиг, аюул ослын үнэлгээг хийлгэж, үнэлгээнд үндэслэн гамшгийн менежментийн төлөвлөгөө боловсруулж, дүүргийн Онцгой байдлын байгууллагаар батлуулах.
- Дахин боловсруулах / сэргээн ашиглах үйл ажиллагааны технологи, үйлдвэрлэлийн схемийг боловсруулан, олон нийтэд нээлттэй байлгах.
- Дахин боловсруулах/сэргээн ашиглах түүхий эд, дахиварыг хүлээн авах байгууламж нь түүхий эд, дахиварыг салхинд хийсэж, тархахаас сэргийлсэн бетон гадаргуутай талбайтай, дээвэр, хашаатай байна.
- Дахин боловсруулах/сэргээн ашиглах компани нь бүтээгдэхүүн, түүхий эдийн найрлага, шинж чанарыг тодорхойлох багаж хэрэгсэл, хэмжилт хийх жин, ачиж, буулгах болон бүтээгдэхүүн, түүхий эдийг шахаж, нягтруулах төхөөрөмжтэй байна.
- Хог хаягдлыг дахин боловсруулах, сэргээн ашиглах түүхий эд, дахивар нь эрүүл ахуйн шаардлага хангасан байх бөгөөд лабораториор туршиж, баталгаажуулах
- Хотын хатуу хог хаягдлаас эрчим хүч үйлдвэрлэх үйлдвэрийг хот дотор болон алсдагдсан суурин газарт барьж болно. Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хүргэж, устгахад хүндрэлтэй алсдагдсан сууринд хог хаягдлыг шатааж эрчим хүч, дулаан үйлдвэрлэх бага оворын үйлдвэрийг барьж болох бөгөөд байгаль орчинд сөрөг нөлөөгүй, байгаль орчныг хамгаалах холбогдох байгууллагаас зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

7.3 Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх

Хог хаягдлын тухай хуулийн 9.1.3-т :

“Аймаг, нийслэлийн ИТХ- энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булах журмыг батална” гэж заасны дагуу **Нийслэлийн ИТХ-ын 2020 оны 2-р сарын 20-ны өдрийн 32/03 дугаар тогтоолоор** энэхүү журмыг баталсан байна.

Журамд хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах, ангилан цуглуулах, тээвэрлэх, нийтийн эзэмшлийн гудамж талбайг цэвэрлэх, хог хаягдлыг дахин боловсруулах, дахин ашиглах, сэргээн ашиглах, устгахтай холбогдсон харилцааг зохицуулах, үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тусгасан.

Мөн, хог хаягдлын цогц менежментийн тогтолцооны хүрээнд оролцогч талуудын үүрэг хариуцлага, харилцаа, иргэд, аж ахуйн нэгжүүд эх үүсвэр дээр нь ангилан ялгах хог хаягдлын төрөл, ангиллыг тодорхойлсон.

Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах, устгах үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагуудад тавигдах хамгийн наад захын шаардлага, дээрх үйл ажиллагааг эрхлэх байгууллагуудын хариуцлагыг нэмэгдүүлэн хог хаягдлын үйлчилгээнд тавих хяналт, мониторингийг сайжруулах, орон сууц, гэр хороололд амьдарч байгаа иргэд хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, аж ахуйн нэгж, байгууллагууд хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгах, цуглуулж, тээвэрлэх зэрэг хог хаягдлын цогц менежментэд оролцогч талуудын харилцааг энэхүү журамд нарийвчлан тусгасан юм.

Журмаар заасан шаардлагуудыг хангасан нийтийн эзэмшлийн зам талбайг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, төрөлжүүлэн ангилах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах аж ахуйн нэгжүүд Байгаль орчны яамны мэдээллийн санд болон нийслэлийн хог хаягдлын менежмент, хяналтын нэгдсэн цахим системд бүртгүүлэх үүрэгтэй.

Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх шаардлагын талаарх мэдээллийг 9 ба 10 дугаар хайрцагт тус тус үзүүлэв.

ХАЙРЦАГ 9: ХОГ ХАЯГДАЛ АНГИЛАХ ШААРДЛАГА

Ахуйн хог хаягдлыг эх үүсвэр дээр нь дараах төрлөөр ангилна.

Орон сууцны айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагууд хог хаягдлаа гурваас доошгүй ангиллаар эх үүсвэр дээр ангилна.

- Дахин боловсруулах боломжтой
- Дахин боловсруулах боломжгүй
- Хүнсний хаягдал

Гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагууд хог хаягдлаа 4 төрлөөр эх үүсвэр дээр ангилна.

- Дахин боловсруулах боломжтой
- Дахин боловсруулах боломжгүй
- Бүх төрлийн үнс¹
- Хүнсний хаягдал

Хог хаягдлын ангиллын төрлүүдэд дараах өнгөний кодыг ашиглана.

- Хуванцар ба гялгар уут - Ногоон
- Хөнгөн цагаан лааз ба металл - Улбар шар
- Цаас - Цэнхэр
- Шил - Цагаан
- Хүнсний хаягдал - Бор
- Бусад хог хаягдал - Хар
- Ахуйн аюултай хог хаягдал – Шар.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагууд хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрийн хүчин чадал, цуглуулалт, тээвэрлэлтийн төрлөөс хамааран журмын (6.2-р зүйл) заасан хамгийн доод ангиллыг хүссэн хэмжээгээр нэмэгдүүлж болно.

Дахивар хүлээн авах, борлуулах цэгүүд нь нийслэлийн худалдаа үйлчилгээний нийтлэг дүрмийг мөрдлөг болгоно.

Энэхүү журмын 6.3-т заасан дахин боловсруулах бүтээгдэхүүн цуглуулах цэг нь байгаль орчинд ээлтэй байхаас гадна дахин боловсруулах түүхий эд, дахиврыг хадгалах зориулалтын талбай, дахиврыг жижиглэх, бутлах, нягтруулах төхөөрөмжтэй байна.

Дор дурдсан хог хаягдал ихээр үүсдэг нийтийн эзэмшлийн гудамж, талбай, олон нийтийн газруудад хог хаягдал үүсэх хэмжээ, төрлөөс хамааран хогийн савны хэмжээ, ангилалтын төрлийг тогтооно.

6.7.1. Зах, худалдааны төв

6.7.2. Үзвэр үйлчилгээний газар

6.7.3. Нисэх онгоцны буудал

6.7.4. Төмөр замын буудал

6.7.5. Автобусны буудал

6.7.6. Таксины зогсоол

6.7.7. Цэцэрлэгт хүрээлэн, парк

6.7.8. Амралт зугаалгын бүс

6.7.9. Тоглоомын талбай

¹Үнсэнд сайжруулсан болон түүхий нүүрсний үнс орно.

ХАЙРЦАГ 10: ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХЭД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ эрхлэгчид дараах хамгийн наад захын шаардлагыг хангасан байх ёстой.

- Орон сууцны хорооллын айл өрх, аж ахуйн нэгжүүдийн дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг долоо хоногт нэгээс доошгүй удаа, дахин боловсруулах боломжгүй болон хүнсний хаягдлыг долоо хоногт гурваас доошгүй удаа, гэр хорооллын хог хаягдлыг ангиллын төрлөөс үл хамааран сард хоёроос доошгүй удаа цуглуулж, тээвэрлэнэ.
- Хог хаягдлын үйлчилгээ эрхлэгч нь айл өрх, а.а.н-ээс хог хаягдлыг цуглуулахдаа ачигч, жолооч нарт аюулгүй, цаг хугацаа, хөдөлмөрийн хэмнэлттэй арга, технологийг сонгох ёстой. Хог хаягдлыг ангилахдаа тусгайлсан уут, хогийн сав ашиглана.
- Орон сууц, аж ахуйн нэгж, нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байрлуулсан хогийн савыг хогны эзлэхүүн, дүүргэлтийг мэдрэх мэдрэгч суурилуулж болох бөгөөд, хогийн савыг дүүрч, халихаас өмнө тогтмол хоослох хэрэгтэй.
- Эх үүсвэр дээр ангилсан хог хаягдлыг бусад хог хаягдлын төрлүүдтэй холихгүйгээр тусад нь цуглуулж тээвэрлэнэ.
- Хог хаягдлыг цуглуулах, ачихдаа санамсаргүй гал алдахаас урьдчилан сэргийлж, 10 метрийн зайд ил гал гаргахыг хориглоно.
- Энгийн хог хаягдлыг ачиж, цуглуулах үед ууталсан хог хаягдлыг уутнаас задлахгүйгээр, хог хаягдлыг ил задгай тархааж хийсгэхгүйгээр ачиж тээвэрлэх
- Энгийн хог хаягдлыг ачсаны дараа хогийн сав, бункер болон орчныг цэвэрлэн эзэмшигчид хүлээлгэж өгөх
- Хогийн савыг эзэмшигчид нь дулааны улиралд сард нэгээс доошгүй удаа, хүйтний улиралд хоёр сард нэг удаа угааж, ариутгана.
- Нийтийн эдэлбэр газар гудамж талбайн хогийн сав болон орон сууцны бункер, а.а.н-ийн хогийн цэгээс хог хаягдлыг шөнийн цагаар цуглуулж, тээвэрлэж болох ба хөдөлмөрийн болон замын хөдөлгөөний аюулгүй ажиллагааг ханган, хангалттай гэрэлтүүлэгтэй орчин гүйцэтгэх
- Хог хаягдал цуглуулж, тээвэрлэх үйлчилгээг жолоочийн хариуцлагын даатгал, авто тээврийн хэрэгслийн даатгал, үзлэг оношилгоонд бүрэн хамруулж, техникийн бүрэн бүтэн байдлыг хангасан автомашинаар гүйцэтгэх
- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх тээврийн хэрэгсэл, компанийн лого, улсын дугаар, үйлчилж буй дүүргийн нэрийг тодорхой байрлуулах.
- Аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7.1 дэх заалтад заасан аргачлалын дагуу эзлэхүүнд суурилж тооцож авна
- Хог хаягдал цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага тээвэрлэж байгаа хог хаягдлын төрөл ангиллаас хамааран хог дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллагатай хог хаягдал нийлүүлэх гэрээ байгуулж ажиллана

8 Хог хаягдлын менежментийн дэд бүтэц

8.1 Хог хаягдлыг хадгалах, ангилах

Нийслэлийн орон сууцны хороолол, гэр хороолол амьдарч буй айл өрх, нийтийн эзэмшлийн талбай, гудамж талбайд холимог хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэхийн өмнө дараах төрлийн савнуудаас байрлуулсан байна. Үүнд:

- 4 м³ эзлэхүүнтэй металл сав
- 10 м³ эзлэхүүнтэй сав
- 50 литрийн жижиг төмөр хогийн сав
- 5 м³ эзлэхүүнтэй хог хаягдлын зориулалтын бункер (хуучин хэв маягийн орон сууцны барилгад).

Гэр хорооллын айлууд 100 литрийн багтаамжтай төмөр торхыг голчлон хог, үнсээ хадгалахад ашигладаг.

Түүнчлэн, орон сууцны хороололд үйл ажиллагаа явуулж буй зарим компани, СӨХ-д өөрсдийн санаачилгаар цаас, хуванцар сав, хөнгөн цагаан лааз зэрэг дахин боловсруулах болон дахин ашиглах боломжтой хог хаягдлыг эх үүсвэр дээр оффисын дотор талд болон гадаа байрлуулсан хогийн саванд ангилан цуглуулдаг. Гэхдээ, айл өрхүүд, аж ахуйн нэгжүүд хүнсний хог хаягдлаа эх үүсвэрээс нь ангилах хадгалах, цуглуулах, тээвэрлэх дэд бүтэц хараахан бүрдээгүй байна.

8.1.1 Хүндрэл, бэрхшээл

УИХ-аас 2017 онд баталсан **Хог хаягдлын тухай хуулийн** шинэчилсэн найруулгаар нийтийн эзэмшлийн талбайд байрлуулах хогийн саванд тавигдах шаардлагыг тусгасан. Үүний дагуу Улаанбаатар хотын гудамж талбайд дээрх шаардлага хангасан хогийн савуудыг байрлуулж эхэлсэн. Гэвч нийслэлийн иргэдийн олонх нь хог хаягдлаа хэрхэн ангилан ялгах талаар ойлголт сул байгаагаас шалтгаалан хогийн савыг зориулалтын дагуу ашиглахгүй байна. Иргэд ихэвчлэн хог хаягдлаа ангилан ялгахгүйгээр ил задгай хаях болон хольж нийлүүлэн хогийн саванд хаядаг.

Түүнчлэн иргэд, а.а.н-үд өөрсдийн санаачилгаар дахин боловсруулах боломжтой хог хаягдлаа эх үүсвэр дээр нь ангилж ялгадаг боловч хог хаягдлыг цуглуулах, ачиж тээвэрлэх явцад бусад хог хаягдалтай холилдон төвлөрсөн цэгт булшлагдаж байна. Энэ нь дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах ялгах сонирхлыг бууруулж, иргэд, а.а.н-үүдийн идэвхи, оролцоог сулруулж байна.

Улаанбаатар хотын гэр хорооллын айлууд ихэвчлэн 100 литрийн төмөр торхонд хогоо хадгалдаг. Гэвч галлагаанаас гарсан халуун үнсийг бусад ахуйн хог хаягдалтай хольж нэг саванд хадгалдаг нь хог хаягдал шатахад хүргэдэг.

8.2 Хог хаягдлыг цуглуулах, ачих

Нийслэлийн дүүргүүдэд хог хаягдлыг гар болон механик аргыг хослуулан цуглуулж, хог тээврийн машинд ачдаг. Гараар ачихдаа ачигч нар хүрз, цаасан уут, хуванцар сав, металл сав зэргийг хэрэглэдэг байна. Зөвхөн Нийслэлийн хот тохижилтын газар нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдлыг цуглуулах, ачихдаа механик ачигч ашигладаг.

Хог хаягдлыг цуглуулах олон төрлийн хэлбэр байна. Үүнд:

- Дуудлагаар,
- Хаалганаас хаалганд,
- Тогтоосон цэгүүдээс,
- Нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байрлуулсан хогны савнаас, мөн
- Урьдчилан тохиролцсон ачилтын хуваарийн дагуу гэх мэт

Нийслэлийн ИТХ хог хаягдлын менежменттэй холбоотой дүрэм, журам, хөтөлбөрийг баталдаг бол дүүргийн Засаг даргын Тамгын газар хог хаягдал цуглуулах, тээвэрлэх хуваарийг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажилладаг байна.

Хүнсний хог хаягдал нь ахуйн хог хаягдалтай хамтад нь цуглуулж, ачдаг бөгөөд одоогоор тусад нь цуглуулж, ачих дэд бүтэц байхгүй байна.

Хүндрэл, бэрхшээл

Улаанбаатар хотын айл өрх, а.а.н-үүдийн хог хаягдлыг хогийн сав болон орон сууцны бункерээс голчлон гар аргаар цуглуулдаг. Ийм систем нь ачих үед хог хаягдал салхинд хийсэх, тоос шороо үүсэх, ачигчийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх, цуглуулах хугацааг уртасгах зэрэг хэд хэдэн сул талуудтай. Мөн гэр хорооллын олон өрх хог хаягдлыг төмөр торхонд хадгалдаг ба энэ нь гараар цуглуулж, ачихад хүнд учир гэр хороололд хоёр ачигч ажиллах шаардлагатай болж, ачиж, тээвэрлэх зардлыг нэмэгдүүлдэг.

8.3 Хог хаягдлын тээвэрлэлт

Улаанбаатар хотын есөн дүүрэгт нийт 27 хог хаягдал цуглуулах, тээвэрлэх компани (өмнө нь ТҮК) үйл ажиллагаа явуулдаг. Үүнд орон нутгийн өмчит 20, хувийн хэвшлийн 7 аж ахуйн нэгж багтаж байна. Эдгээр аж ахуйн нэгжүүд хогоо Япон, Солонгос, Хятадад үйлдвэрлэсэн тээврийн хэрэгслээр тээвэрлэж байна. Өдөр бүр задгай тэвштэй 161, хог нягтруулагч механизм бүхий битүү тэвштэй 134, нийт 295 ачааны машиныг хог тээврийн үйлчилгээнд гардаг бөгөөд 90% нь хуучирсан буюу ашиглалтын хугацаа дууссан, 10% нь шинэ буюу шинэвтэр машин юм. Эдгээр ачааны автомашины 234 нь нийслэлийн өмчид бүртгэлтэй ба 61 нь хувийн хэвшлийнх байна. Эдгээр ачааны машинууд бүгд GPS системээр тоноглогдсон бөгөөд холимог хог хаягдлыг цуглуулах зориулалттай. Даацын хувьд ачааны машины төрлөөс хамаарч өөр өөр байдаг ба, тухайлбал, нягтруулагч машин 3-8 тн, задгай тэвштэй машин 5-8 тн, өөрөө буулгагч машин 5-10 тн-ын даацтай.

Хог хаягдлыг ангилан ялгах ажлыг 2017 онд анх эхлүүлэхэд хот, дүүргийн захиргаанаас дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг дүүргийн тохижилт үйлчилгээний компаниудаар (ТҮК) тээвэрлүүлэх ажлыг туршилтаар хэрэгжүүлсэн боловч хог хаягдал тээвэрлэх машин хүрэлцээгүй улмаас ангилсан хог хаягдлыг бусад хог хаягдалтай хольж тээвэрлэж эхэлсэн нь иргэдийг бухимдуулахад хүргэж байв. Ийм байдлыг өөрчлөхийн тулд хог хаягдал дахин боловсруулах үйлдвэрүүдэд ангилсан хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ үзүүлэхийг санал болгосон боловч хог хаягдал тээвэрлэх машин байхгүй, боловсон хүчин хангалттай гэсэн шалтгаанаар татгалзсан байна.

Хүндрэл, бэрхшээл

2006-2018 онуудад хог тээврийн хэрэгслийн парк шинэчлэлтийн хүрээнд 374 хог тээврийн зориулалтын авто машин худалдаж авснаас 140 нь эвдэрч, цаашид ашиглах боломжгүй болсон байна. Хэдийгээр парк шинэчлэлийг хамгийн сүүлд 2018 онд хийсэн ч тээврийн автомашинууд замын нөхцөл байдал, даац хэтрүүлэн ачдагаас шалтгаалан эвдэрч гэмтэх, ашиглалтын хугацаа дуусч, хуучирсан зэргээс шалтгаалан үйлчилгээ үзүүлэх боломжгүй болж, хог хаягдал цуглуулах, тээвэрлэх хуваарь зөрчигдөж, нийтийн эзэмшлийн талбай, гудамж талбайд хог хаягдал ихээр үүсэх гол шалтгаан болоод байна.

8.4 Хүнсний хог хаягдлыг бордоогоор дахин боловсруулах

Одоогоор нийслэлд гурван аж ахуйн нэгж органик хаягдал дахин боловсруулж компост үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхэлж байна.

Эко Тайхи ХХК

Тус компани СХД-ийн 20-р хороонд 2018 оноос малын гаралтай органик хаягдлаар компост боловсруулж эхэлсэн. Тэд компостын боловсрох үйл явцыг хурдасгахын тулд зах зээлээс бэлтгэсэн бэлэн бактерийг ашигладаг бөгөөд энэ нь амьтны гаралтай хог хаягдлын үлдэгдлийг түргэн задлах, үнэр дарахад үр дүнтэй гэж үздэг.

TJ Recycling ХХК

Тус компани нь Баянзүрх дүүргийн 8-р хороонд байрладаг ба 2.4 га газрын 1 га-д компостын үйлдвэрлэл, үлдсэн 1.4 га-д мод үржүүлгийн үйл ажиллагаа эрхэлж байна. Тус компани E-mart сүлжээ дэлгүүр, АПУ, Таван богд зэрэг үндэсний цөөн хэдэн хүнс, ундаа үйлдвэрлэгчидтэй гэрээ байгуулж, хүнсний хаягдал цуглуулан боловсруулж компост үйлдвэрлэж байна.

2022 онд тэд нуруулдах аргаар 100 тонн компост үйлдвэрлэжээ. Тэд үйлдвэрлэсэн компостоо зах зээлд нийлүүлэхгүйгээр өөрсдийн мод үржүүлгийн бизнест ашигладаг.

МСРТ ХХК

Тус компани СХД-ийн 20 хорооны нутаг дэвсгэрт 1 га газар хамарсан талбайд компост хийх үйлдвэрлэлийг эрхэлдэг бөгөөд гол төлөв үхрийн бууцыг түүхий эд болгон ашигладаг.

Хүндрэл, бэрхшээл

Хүнсний хаягдал дахин боловсруулагчид Эмээлт орчмын мах бэлтгэдэг компаниуд, зарим супермаркетууд, фермерүүд, хүнсний үйлдвэрүүдээс түүхий эдээ буюу хүнсний хаягдлыг цуглуулдаг. Гэсэн хэдий ч хол зайнаас (түүхий эд нийлүүлэгчээс компостын үйлдвэрлэл хүртэл дунджаар 90 км зайтай) түүхий эд, хүнсний хаягдлыг цуглуулдгаас тээврийн зардал өндөр байдаг байна.

Одоогийн байдлаар хүнсний хаягдлаар хийсэн компостын нь зах зээлийн үнэ бага, иргэд, аж ахуйн нэгжүүд компост хэрэглэх туршлагагүй тул компостын зах зээл дээр өрсөлдөх чадвар сул байна. Одоогоор компост бордооны үйлдвэрлэл, хэрэглээ, нийлүүлэлтийг эдийн засгийн урамшууллаар дэмжих төрийн болон орон нутгийн бодлого дутмаг байна.

8.5 Хог хаягдлыг булшлах, ландфиллын үйл ажиллагаа

Улаанбаатар хотод Цагаан даваа, Нарангийн энгэр, Морингийн даваа зэрэг гурван хог хаягдлын төрлөсөн цэг үйл ажиллагаа эрхэлж байгаа бөгөөд дээрх хог хаягдлын төвлөрсөн цэгүүдийг нийслэлийн өмчит “Хот тохижилтын газар” үйл ажиллагааг хариуцан ажиллаж байна. “Улаанбаатар хотын хүнсний хаягдлыг дахин боловсруулах” төслийн хүрээнд хийсэн судалгаагаар жилд 130 гаруй мянган тонн хүнсний хаягдал гарч байгаа бөгөөд дээрх хог хаягдлын төвлөрсөн цэгүүдэд дарж, булшлагдаж байна.

9 Хог хаягдлын менежментийн санхүүжилт ба төсөв

Хог хаягдлын менежментийн үйлчилгээг айл өрхөөс цуглуулсан хог хаягдлын үйлчилгээний хураамж болон нийслэлийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлдэг. 2013 оны 1-р сараас эхлэн гэр хороололд оршин суудаг айл өрхүүдээс хог хаягдлын үйлчилгээний хураамжийг цахилгааны төлбөрийн хамт авч эхэлсэн. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг цахилгааны төлбөртэй цуг иргэд арилжааны банкинд тушааж, улмаар арилжааны банкуудаас Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ компанид (УБЦТС) шилжүүлдэг бөгөөд уг компани хог хаягдлын үйлчилгээний хураамжаас цугларсан орлогыг дүүргүүдийн татварын хэлтэс, дүүргийн төрийн сангийн нэгдсэн данс руу шилжүүлдэг. Төвлөрсөн цэгт хүргэгдсэн хог хаягдлын хэмжээ, рейсын тоог үндэслэн дүүргийн төрийн сангийн хэлтсүүд хог хаягдлын үйлчилгээний компани, а.а.н-үүдэд санхүүжилтийг олгодог.

Хог хаягдлын хураамж авах арга нь гэр хороолол, орон сууцны хороололд ялгаатай.

- Гэр хорооллын айл өрхүүдийн хог хаягдлын хураамжийг цахилгааны төлбөрийн хамт авдаг.
- Орон сууцны хорооллын айл өрхүүдийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг ус, дулааны үйлчилгээний төлбөртэй хамт Орон сууц, нийтийн аж ахуйн газар авдаг.

Орон сууцны оршин суугчид болон гэр хорооллын иргэдийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ ч харилцан адилгүй байна. Нийслэлийн Засаг даргын 2006 оны 182 дугаар захирамжийн дагуу орон сууцанд амьдарч буй айл өрх сард 2,000 төгрөг, гэр хорооллын айл өрх 2,500 төгрөг төлж байгаа нь өнөөг хүртэл өөрчлөгдөөгүй байна. Гэр хорооллын айл өрх төлөвлөгдөөгүй суурьшлын бүсэд сийрэг суурьшдаг, замын нөхцөл байдал муу тул хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх үйлчилгээ үзүүлэхэд илүү их хөрөнгө мөнгө шаардагдах тул орон сууцны айл өрхөөс үйлчилгээний хураамжийн өндрөөр тогтоосон. Аж ахуйн нэгж, байгууллагуудын хувьд дүүрэг бүр а.а.н-ийн үйл ажиллагааны цар хүрээ, онцлогоос хамаарч өөр өөр хураамж авдаг. Нийслэл, дүүргийн төсвөөс төвлөрсөн хогийн цэгүүдийн үйл ажиллагаа, нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээг санхүүжүүлдэг.

Хог хаягдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.9-д Хог хаягдлын үйлчилгээний хураамжаас хуримтлагдсан орлогыг дараах зориулалтаар зарцуулна гэж заасан.

- Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх,
- Хог хаягдлыг булшлах, болон
- Үйлчилгээний төлбөрийг цахилгаан болон бусад нийтийн үйлчилгээний байгууллагуудаар дамжуулан хураасан тохиолдолд үйлчилгээний шимтгэл төлөх

Түүнчлэн Хог хаягдлын тухай хуульд нийтийн эзэмшлийн гудамж талбайг цэвэрлэх, хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг сурталчлах, олон нийтийг хамарсан их цэвэрлэгээний аян, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулахад аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвөөс санхүүжүүлэхээр заасан байдаг. Гэвч, ч орон нутгийн төсвийн хязгаарлалт, хүрэлцээгүй байдлаас шалтгаалан хог хаягдал дахин боловсруулах үйл ажиллагааг дэмжихэд зориулж ямар нэгэн санхүүжилт хуваарилдаггүй байна.

Хүндрэл, бэрхшээл


Нийслэлийн Засаг дарга 2006 оны 182 дугаар захирамжаар хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоосон бөгөөд өнөөдрийг хүртэл өөрчлөгдөөгүй байна. 2006 оноос хойш дизель түлшний үнэ 2.4 дахин, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 6 дахин нэмэгдсэнээр хог хаягдал цуглуулах, тээвэрлэх зардал асар их өссөн юм. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх аж ахуйн нэгжүүдийг хог хаягдлын үйлчилгээний хураамжийн

орлогоор санхүүжүүлэх боломжгүй тул, нийслэл, дүүргийн төсвөөс жилд 10 орчим тэрбум төгрөгийн татаасыг хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйлчилгээний санхүүжилтэд олгож байна. Хог хаягдлын тухай хуульд аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийг үүсэж буй хог хаягдлын хэмжээгээр тооцож, айл өрхийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэг хүнээр тооцож тогтоохоор заасан ч харамсалтай нь айл өрхийн ам бүлийн тооны бүртгэлийн цахим систем дутагдалтайгаас шалтгаалан хуулийн заалт өнөөдрийг хүртэл хэрэгжээгүй байна.

10 Хүнсний хаягдлын менежментийн үе шат

Энэ бүлэгт хүнсний хаягдлаас компост үйлдвэрлэх үе шатанд хамаарах хууль тогтоомжийн үндсэн хэрэгслүүдийг тусгасан болно.

Хүнсний хаягдлаас компост боловсруулах хүртэл үе шат



10.1 Хүнсний хаягдлыг хадгалах

Хүнсний хаягдлыг хэрхэн хадгалах талаар тодорхой дүрэм, журам байдаггүй бөгөөд хүнсний хаягдал цуглуулах төлөвлөлт, дэд бүтэц мөн байхгүй. Иймд, хүнсний хаягдлын талаар шинэ дүрэм, журам боловсруулан нэвтрүүлэхэд хүндрэл гарч болзошгүй.

Орон сууц

Оршин суугчид болон тээвэрлэгчдийн хувьд хүнсний хаягдлыг төвлөрсөн хог хадгалах байгууламж эсвэл хогийн цэгээр дамжуулан цуглуулах систем нь хамгийн хялбар байдаг. Гэвч, хадгалах явцад үнэр гарах, ялаа, мэрэгч цуглах зэрэг асуудал үүсч, улмаар нийгмийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Хог хаягдлыг хадгалах байгууламж, цуглуулах цэгийн одоогийн систем нь оршин суугчдад хүнсний хаягдлаа ангилах таатай нөхцөлийг бүрдүүлдэггүй.

Дуудлагаар хог хаягдлыг цуглуулах систем нь хамгийн тохиромжтой сонголт байж болох юм.

Гэр хороолол

Гэр хорооллын айл өрхөд хүнсний хаягдал цуглуулах үйлчилгээ хараахан нэвтрээгүй байна.

10.2 Хүнсний хаягдлыг цуглуулах, тээвэрлэх

Хог хаягдлыг цуглуулах үйлчилгээ тогтмол бус, тодорхойгүй ба хүнсний хаягдлыг бусад хог хаягдалтай хольж тээвэрлэж байна.

Одоогийн хууль, эрх зүйн орчны хүрээнд гүйцэтгэлийг үнэлэх, хариуцлага тооцох, санхүүжилтийг тодорхой болгох, хяналтыг сайжруулах арга хэмжээг авч хэрэгжүүлснээр хүнсний хаягдал цуглуулж, тээвэрлэх тогтолцоог сайжруулах боломжтой. Түүнчлэн хог хаягдлын менежментийн үр ашгийг дээшлүүлэхийн тулд нээлттэй, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх шаардлагатай.

10.3 Хүнсний хаягдлыг дахин боловсруулалт, компост

Өнөөгийн байдлаар зөвхөн хувийн хэвшлийн санаачлагаар хүнсний хаягдлаар компост үйлдвэрлэх үйл ажиллагаа явагдаж байгаа бөгөөд энэ зорилгоор бага хэмжээний хүнсний хаягдлыг цуглуулж байна (8.4. Хүнсний хаягдлыг дахин боловсруулах үйл ажиллагаа дөнгөж эхлэлийн шатанд явж байна.

10.4 Хүнсний хаягдлыг устгах

Хүнсний хаягдлыг бусад ахуйн хаягдлын хамт төвлөрсөн хогийн цэгүүдэд булшилж устгаж байна. Хүнсний хаягдал нь ялзрах явцдаа метан хий болон таагүй үнэр ялгаруулж, хортон шавьжийг цуглуулан агаар, хүрээлэн буй орчныг бохирдуулдаг.

Хүнсний хаягдлыг ачсан тээврийн хэрэгсэлд тавих хяналт сул, хогийн цэгийн өөр өөр байршилд төрөл бүрийн хогийг хяналтгүйгээр хаяж байна.

Хогийн цэгүүдэд метан хийг цуглуулах, боловсруулах дэд бүтэц байхгүйгээс агаар мандалд шууд тархаж байгаа юм.

10.5 Тээврийн хэрэгсэл, машин механизм, тоног төхөөрөмжийн ашиглалт

Хүнсний хаягдлыг цуглуулах, тээвэрлэх тусгай зориулалтын автомашин одоогоор байхгүй байна. Одоо байгаа машинууд хүнсний хаягдлыг тусад тээвэрлэх тоног төхөөрөмжгүй байгаа болно.

Хог хаягдал тээвэрлэлтийн компаниуд (ТҮК) хүнсний хаягдлыг ангилан цуглуулах талаар мэдлэг, мэдээлэл дутмаг, жолооч, ачигч бэлтгэх сургалтын хөтөлбөр байхгүй байна.

10.6 Удирдлага ба зохион байгуулалт

Дүүргүүд хог тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээндээ хүнсний хаягдлыг тусгайлан тээвэрлэх талаар ямар нэгэн заалт тусгаагүй байна.

Хог хаягдал тээвэрлэгч аж ахуйн нэгжүүд хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааныхаа гүйцэтгэлийг хэрэглэгч болон оршин суугчид, аж ахуйн нэгж, байгууллагад тайлагнадаггүй.

Хүнсний хаягдлыг хууль бусаар хаяж буй иргэд, аж ахуйн нэгжүүдэд тавих хяналт, шалгалт сул, байцаагчийн орон тоо хангалтгүй, нийслэл, дүүргийн ажилтнууд торгууль, шийтгэл оногдуулах эрхгүй байна.

Хог хаягдлын үүсэлтийн хэмжээ, бүтцийн талаар болон хог хаягдлын үйлчилгээнд хамрагдаагүй оршин суугчдын мэдээлэл, хог хаягдлын үйлчилгээний төлбөр төлж буй оршин суугч, аж ахуйн нэгжийн бүртгэлийн талаарх суурь мэдээлэл хангалтгүй байна.

Дээрх суурь мэдээлэл хангалтгүй байгаагаас шалтгаалан хог хаягдлын менежментийн бүрэлдэхүүн хэсэг (хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, хогийн төвлөрсөн цэгт устгах, гудамж, зам талбайн цэвэрлэгээ гэх мэт) зардлын тооцоо тодорхойгүй байна. Тиймээс суурь мэдээлэл цуглуулж, зохих мэдээллийн санг бий болгох зайлшгүй шаардлагатай.

10.7 Санхүүгийн систем

Хог хаягдал тээвэрлэгч аж ахуйн нэгжүүд (ТҮК) зардлын нарийвчилсан тооцооллын системгүй, хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаанд төсөвлөсөн санхүүжилт хангалтгүй байна.

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг айл өрхөөр тооцож тогтоосон нь Хог хаягдлын тухай хууль болон “Бохирдуулагч нь төлөх” зарчимд нийцэхгүй байна. Одоогоор айл өрхийн гишүүдийн тооноос үл хамааран ижил хэмжээний хураамж авч байна. Өрхийн гишүүдийн тооноос хамааран хог хаягдал үүсэх хэмжээ харилцан адилгүй байдаг тул нэг хүнээр бодож үйлчилгээний хураамжийг тогтоох шаардлагатай.

Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэхэд зарцуулсан зардлын зөрүүгээс шалтгаалан² орон сууц, гэр хороололд оршин суугчид айл өрх харилцан адилгүй төлбөр төлдөг. Иймд, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур амьдардаг гэр хорооллын айл, өрх орон сууцанд амьдардаг иргэдээс илүү төлбөр төлөх шаардлагатай болдог.

² Учир нь гэр хорооллын автозамын чанар муу, хашаанаас шууд хог хаягдал ачдаг.

11 Дүгнэлт

Тогтвортой хөгжил, хаягдалгүй, тойрог эдийн засгийн талаар хууль тогтоомж, бодлого, төлөвлөгөө нь стратеги төлөвлөлт, үйл ажиллагааны цогц тогтолцоог бүрдүүлдэг. Эдгээр стратеги төлөвлөлт, үйл ажиллагаанууд нь Монгол Улсын хог хаягдлын менежментийг сайжруулах, дахин боловсруулалтын түвшинг дээшлүүлэхэд чиглэгдсэн байдаг.

Хог хаягдлын тухай хууль нь хог хаягдлын менежментийг зохицуулдаг хууль тогтоомжийн суурь эрх зүйн баримт бичиг юм. Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, боловсруулах, устгах үйл ажиллагааны талаар нарийвчилсан шаардлагыг хуульчилсан байдаг. Хэдийгээр хууль эрх зүйн орчин ийнхүү бүрдсэн ч хэрэгжилт хангалтгүй байгаа юм. Энэ нь харилцан хамаарал бүхий олон хүчин зүйлсээс шалтгаалж байна. Үүнд:

- Иргэд хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилан ялгаж, хогийн савыг ашиглах талаар ойлголт, мэдлэг дутмаг .
- Хог хаягдлыг цуглуулсны дараа ангилан ялгаж тээвэрлэдэггүй нь эх үүсвэр дээр ангилж ялгасан иргэдийн идэвхийг бууруулдаг.
- Хог хаягдлыг хогийн бункерээс гараар цуглуулж, ачих нь хөдөлмөрийн аюулгүй байдлыг алдагдуулдаг.
- Хог тээврийн автомашин хуучирсан, эвдрэл гэмтэл байнга гарч, засвар үйлчилгээ хийлгэхээс шалтгаалан хог хаягдал цуглуулах, тээвэрлэх хугацаа, хуваарь мөрдөгдөхгүй байх, хойшлох, эсвэл цуцлагдахад хүргэдэг.
- 2006 оноос хойш нэмэгдээгүй хог хаягдлын үйлчилгээний хураамжийг айл өрх, аж ахуйн нэгжээс авч байгаа нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх аж ахуйн нэгжүүд шаардлага хангасан үйлчилгээний үзүүлэх санхүүгийн хувьд боломжгүй байдлыг бий болгож байна. Нийслэлийн хог хаягдал дахин боловсруулах түвшинг нэмэгдүүлэхийн тулд нэн яаралтай санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай. Улаанбаатар хотын хог хаягдлын менежментийн санхүүжилт хангалтгүй байгаа нь шугаман эдийн засгаас хаягдалгүй, тойрог эдийн засагт шилжих тогтолцооны өөрчлөлтийг хийх шаардлагатайг харуулж байна.
- 2017 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан Хог хаягдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгаар хог хаягдлыг үйлчилгээний хураамжийг аж ахуйн нэгж, байгууллагаас үүсч буй хог хаягдлын хэмжээгээр, айл өрхийн төлбөрийг нэг хүнээр тооцох тухай заасан боловч одоогоор энэ заалтыг хэрэгжүүлээгүй байна. Энэ нь улсын бүртгэлийн цахим систем хангалтгүй байгаатай холбоотой.
- Хүнсний хаягдлыг хэрхэн хадгалах, цуглуулах талаар батлагдсан тодорхой дүрэм журам байдаггүй. Энэ шалтгаанаар шинэ дүрэм, журам нэвтрүүлэхэд хүндрэл гарч болзошгүй.

Улаанбаатар хотын хүнсний хаягдлыг дахин боловсруулах төслийн хувьд туршилтын төслүүдийг өргөжүүлэх, тогтвортой байдлыг хангах, ялангуяа том хэмжээний туршилтын төслийг хэрэгжүүлэхэд дээрх бүх хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай.

12 Хавсралт 1

№	Төрөл	Эрх зүйн бичиг баримт бичгүүд	URL хаяг
1	Хууль	Монгол улсын үндсэн хууль	The Constitution of Mongolia
2	Хууль	Химийн хорт болон аюултай бодисын тухай	Law on Hazardous and Toxic Chemicals http://www.legalinfo.mn/law/details/526
3	Хууль	Хог хаягдлын тухай	Law on Waste http://www.legalinfo.mn/law/details/8666
4	Хууль	Агаарын бохирдолын тухай хууль	Law on Air pollution
5	Хууль	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль	Law on Water Pollution Fees
6	Тогтоол	Монгол улсын засгийн газрын тогтоол No298, 2014.09.18. Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр батлах тухай	Mongolian Government Resolution No298, 18 Sep 2014. to approve National Strategy on improvement of Solid waste management http://www.legalinfo.mn/law/details/10628
7	Тогтоол	Монгол улсын ЗГ-ын тогтоол No95, 1998. Байгаль орчинд халгүй, технологи нэвтрүүлсэн иргэн, а.а.н байгуулагыг урамшуулах журам батлах тухай	Mongolian Government Resolution No95, 1998. http://www.legalinfo.mn/annex/details/989?lawid=2457
8	Тогтоол	Монгол улсын засгийн газрын тогтоол No 264, 2015. Аюултай хог хаягдлын жагсаалт батлах тухай	Hazardous waste classifications system in Mongolia, Resolution no. 264 dated 29 June 2015 http://www.legalinfo.mn/annex/details/6846?lawid=11218
9	Тогтоол	Монгол улсын засгийн газрын тогтоол No 288, 2015. Хог хаягдлын норматив тогтоох аргачлал батлах тухай	Hazardous waste classifications system in Mongolia, Resolution no. 264 dated 29 June 2016 http://www.mne.mn/mn/news/show/2599
10	Тогтоол	Сайдын тушаал No 93. 2011. Эмнэлэгийн хог хаягдалын системийн санхүүжих, түүнийг тооцох тухай	Ministerial order No: 93 (2011) Regarding the calculation and financing of the healthcare waste system http://www.legalinfo.mn/
11	Тогтоол	Сайдын тушаал No 158. 2011. Эрүүл мэндийн байгууллагаас үүсэх хог хаягдлыг ангилах, цуглуулах, хадгалах, тээвэрлэх, хаях аргачлал батлах тухай	Ministerial order No: 158 (2011/05/03): Regarding the approval of guidelines to classify, collect, store, transport, disinfect, and dispose the waste from healthcare organizations; http://www.legalinfo.mn/
12	Тогтоол	Сайдын тушаал No 179. 2011. Эрүүл мэндийн байгууллагаас үүсэх хог хаягдлын байгууламж болон тоног төхөөрөмжийн зааварчилгаа батлах тухай	Ministerial Order No: 179 (2011/05/31): Regarding the approval of waste facility and equipment guidelines of healthcare organizations. http://www.legalinfo.mn/
13	Тогтоол	Сайдын тушаал No 305/320. 2011. Эмнэлэгийн хог хаягдалын ялгах, хаях, цуглуулах, тээвэрлэх, хаях, боловсруулах тухай	Joint Ministerial Order No: 305/320(2011/09/28): Regarding regulation on medical waste separation, segregation and collection, transportation, disposal, treatment for medical waste. http://www.legalinfo.mn/
14	Үндэсний хөтөлбөр	Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр. 2014	National Strategy on improvement of Solid waste management. 2014 http://www.legalinfo.mn/annex/details/6519?lawid=10628
15	Үндэсний хөтөлбөр	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчныг сайжруулах	National Strategy on improvement of Health Care Waste Management and Action Plan for 2009-2013
16	Үндэсний хөтөлбөр	Монгол Улсын XXI зууны тогтвор-той хөгжлийн хөтөлбөр /1998 он/	Mongolian Action Plan for The 21st Century /1998/

Үйл ажиллагаа 3.7. Туршилтын төслүүдийн цар хүрээг нэмэгдүүлэх хууль, эрх зүй болон байгууллагын тогтолцооны судалгаа

№	Төрөл	Эрх зүйн бичиг баримт бичгүүд	URL хаяг
17	Үндэсний хөтөлбөр	Хог хаягдлыг бууруулах тухай хөтөлбөр, Засгийн газрын 1999 оны 50-р тогтоол	National Programme on Waste Reduction /Res. #50, 1999/
18	Үндэсний хөтөлбөр	Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Үндэсний хөтөлбөр	National Programme on Persistent Organic Pollutants
19	Аргачлал	Хог хаягдлын норматив тогтоох аргачлал	Methodology for calculating waste norms http://www.mne.mn/mn/news/show/2599
20	Журам	Байгаль орчинд халгүй, технологи нэвтрүүлсэн иргэн, аж ахуй нэгж байгуулагыг урамшуулах журам	Procedure on the incentive to be provided to citizens and business entities for introduction of environmentally sound technology http://www.legalinfo.mn/annex/details/989?lawid=2457
21	Журам	Хог хаягдал булах, устгах зориулалтын байгууламж, төвлөрсөн цэгийн төрөл, тэдгээрт тавигдах шаардлага, хог хаягдал булах, устгах үйл ажиллагаа эрхлэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны тухай журам. Байгаль орчны сайдын 2006 оны 404 дүгээр тушаалаар батлагдсан	Procedure on the types of waste disposal and burial facilities and points, requirements thereon, and the operation of citizens, business entities and organizations that will run waste burial http://www.legalinfo.mn/annex/details/5151?lawid=8119
22	Журам	Хог хаягдлын мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээллээр үйлчлэх журам. 2014.04.09. БОНХСайдын А-115 дугаар тушаалаар баталсан	Procedure on creation of waste database and information service http://www.legalinfo.mn/law/details/10401
23	Журам	Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам. 2014.04.09. БОНХСайдын А-116 тоот тушаалаар баталсан.	Procedure on maintaining and reporting of national waste inventory http://www.legalinfo.mn/annex/details/6387?lawid=10402
24	Олон улсын гэрээ, конвенц	Аюултай хог хаягдалыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай Базелийн Конвенц	Basel convention on the control of transboundary movements of hazardous wastes and their disposal http://www.mne.mn/chemical/images/content/uploaded/Angilal/Baselconvention_4ae01c95767bc.htm
25	Олон улсын гэрээ, конвенц	Аюулгүй зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх, урьдчилан мэдээлж зөвшилцөх журмын тухай Роттердамын конвенц	the Rotterdam Convention on the Prior Informed Consent Procedure for Certain Hazardous Chemicals and Pesticides in International Trade http://www.mne.mn/chemical/images/content/uploaded/Angilal/RotterdamConv_4ae01cf57deea.htm
26	Олон улсын гэрээ, конвенц	Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай Стокгольмийн Конвенц	Stockholm Convention on Persistent Organic Pollutants http://www.mne.mn/files/page778/4%20STOKOLM.pdf
27	Стандарт	MNS 5344:2011. Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага	MNS 5344:2011. General requirements for the economical dust transportation http://www.estandard.gov.mn/index.php?module=standart&cmd=full_list&id=218
28	Стандарт	MNS 5479:2005. Аюул учруулах барааны эерэг хамгаалалт. Химийн хорт бодисын хаягдлыг устгахад тавигдах шаардлага	MNS 5479:2005. Protection against of the dangerous goods. Requirement on the method for disposal waste of toxic chemicals http://www.estandard.gov.mn/index.php?module=standart&cmd=full_list&id=219
29	Стандарт	MNS 6342:2012. Агаарын чанар. Аюултай хог хаягдал шатаах зуухны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	MNS 6342:2012. Maximum permissible level of some air pollutants in flue gas from the hazardous waste incinerator http://www.estandard.gov.mn/index.php?module=standart&cmd=full_list&id=220

№	Төрөл	Эрх зүйн бичиг баримт бичгүүд		URL хаяг
30	Стандарт	MNS 6501 :2015. Байгаль орчин.Арьс шир, үслэг боловсруулах үйлдвэрийн хаягдлын ерөнхий ангилал, код	MNS 6501 :2015. Classification and code of wastes from leather and fur tanning	http://www.estandard.gov.mn/index.php?module=standart&cmd=full_list&id=221
31	Стандарт	MNS 6487:2014. Байгаль орчин. Газрын тос боловсруулах үйлдвэрийн хаягдлын ангилал. Хаягдлын байгууламжид тавих ерөнхий шаардлага	MNS 6487:2014. Environment. General Requirement and Waste. Classification of Mineral Oil Refineries	http://www.estandard.gov.mn/index.php?module=standart&cmd=full_list&id=222
32	Стандарт	MNS ISO 6851:2002. Гэрэл зураг. Боловсруулалтын хаягдал. Нийт амины бүлгийн азот тодорхойлох арга (Бичил нэвчилтийн Кьелдалын арга)	MNS ISO 6851:2002. Photography – Processing waste – Determination of total amino nitrogen (microdiffusion Kjeldahl method)	http://www.estandard.gov.mn/index.php?module=standart&cmd=full_list&id=223
33	Стандарт	MNS ISO 6853:2002. Гэрэл зураг. Боловсруулалтын хаягдал. Аммоны дахь азот тодорхойлох арга (Бичил нэвчилтийн арга)	MNS ISO 6853:2002. Photography – Processing waste – Determination of ammoniacal nitrogen (microdiffusion method)	http://www.estandard.gov.mn/index.php?module=standart&cmd=full_list&id=224
34	Стандарт	MNS ISO 6962:2002. Цацраг идэвхи ихтэй хатуу хаягдлыг удаан хугацаанд тогтвортой байх альфа цацрагийг шүлтгүйжүүлэх сорилтын эталон арга	MNS ISO 6962:2002. Standard method for testing the long-term alpha irradiation stability of solidified high-level radioactive waste forms	http://www.estandard.gov.mn/index.php?module=standart&cmd=full_list&id=225
35	Стандарт	MNS ISO 7760:2002. Гэрэл зураг. Боловсруулалтын хаягдал. Гидрохинон тодорхойлох арга	MNS ISO 7760:2002. Photography – Processing waste – Determination of hydroquinone	http://www.estandard.gov.mn/index.php?module=standart&cmd=full_list&id=226
36	Стандарт	MNS 5975:2009. Бохир усан дахь өөх тос баригч төхөөрөмж. Техникийн ерөнхий шаардлага	MNS 5975:2009. Grease catcher equipment in waste water . General requirements	http://www.estandard.gov.mn/index.php?module=standart&cmd=full_list&id=227
37	Стандарт	MNS 3438:1983. Хоёрдогч түүхий эд. Өнгөт төмөрлөгийн хаягдал. Техникийн ерөнхий шаардлага.	MNS 3438:1983. Auxiliary raw material. Waste of nonferrous. Technical requirement	http://www.estandard.gov.mn/index.php?module=standart&cmd=full_list&id=228
38	Стандарт	MNS 0017-2-0-07: 1979. Агаарыг бохирдуулах хаягдал. Ангилал	MNS 0017-2-0-07: 1979. Waste to air pollution. Classification	http://www.estandard.gov.mn/index.php?module=standart&cmd=full_list&id=229
39	Стандарт	MNS 0017-2-1-17: 1980. Агаар мандал. Үйлдвэрийн хаягдал, бохирдлын цаг уурын холбогдолтой нэр томьёо, тодорхойлолт	MNS 0017-2-1-17: 1980. Atmosphere. Vocabulary Waste of industry and pollution related to climate	http://www.estandard.gov.mn/index.php?module=standart&cmd=full_list&id=230
40	Стандарт	MNS 3383: 1982. Агаар мандал. Бохирдлын эх үүсвэр. Нэр томьёо, тодорхойлолт.	MNS 3383: 1982. Air space. Spring of pollution. Determination formulation	http://www.estandard.gov.mn/index.php?module=standart&cmd=full_list&id=231
41	Стандарт	MNS 5606-1:2016. Байгаль орчны хамгаалал. Чандарлах зуух (крематор)-ны яндангаар агаар мандалд хаягдах утааны найрлага дахь агаар бохирдуулах зарим бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ	MNS 5606-1:2016. Environmental protection. Emission limit and for the crematoria working by diesel fuel	http://www.estandard.gov.mn/index.php?module=standart&cmd=full_list&id=232
42	Стандарт	MNS ISO 11632: 2005. Байгаль орчин. Суурин эх үүсвэрээс ялгарах хаягдал. Хүхэрлэг хийн масс агууламжийг тодорхойлох. Ионы хроматографын арга	MNS ISO 11632: 2005. Determination of mass concentration of sulfur dioxide– Ion chromatography method	http://www.estandard.gov.mn/index.php?module=standart&cmd=full_list&id=233